



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО



ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН
БАЙГУУЛЛАГА

БИЕЭ ҮНЭЛЭГЧ БОЛОН БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ХҮҮХДИЙН СУДАЛГАА. 2010

УЛААНБААТАР ХОТ

2010 ОН

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

БИЕЭ ҮНЭЛЭГЧ БОЛОН
БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ХҮҮХДИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2010 ОН



Монгол Улсын Үндэсний
Статистикийн Хороо



Олон Улсын Хөдөлмөрийн
байгууллага

БИЕЭ ҮНЭЛЭГЧ БОЛОН БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ХҮҮХДИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2010 ОН

Энэхүү тайланг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргав.

Хаяг:

Үндэсний Статистикийн Хороо
Засгийн газрын III байр
Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар
Монгол Улс
Цахим шуудан: nso@magicnet.mn
Факс: 976-11-324518

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	4
Зургийн жагсаалт	5
Товчилсон үгийн жагсаалт	7
Бүлэг 1. Ерөнхий тойм	9
1.1 Судалгааны зорилго, ач холбогдол	10
1.2 Тайлангийн бүтэц, агуулга	11
1.3 Судалгааны товч дүн	12
Бүлэг 2. Судалгааны арга зүй, зохион байгуулалт	18
2.1 Судалгааны хамрах хүрээ	19
2.2 Судалгааны түүвэрлэлт	20
2.3 Судалгааны асуулгын хуудас	21
2.4 Туршилтын судалгаа	22
2.5 Судалгааны зохион байгуулалт	22
2.6 Судалгааны ахлагч, судлаач нарын сургалт	23
2.7 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	23
2.8 Судалгааны давуу болон сул талууд	24
2.9 Мэдээлэл цуглуулах явцад тохиолдсон хүндрэл, бэрхшээл, даван туулсан байдал, сургамж	25
Бүлэг 3. Биеэ үнэлэгчид	28
3.1 Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлэг, дүүргээр, байршлаар	29
3.2 Биеэ үнэлэгчдийн ерөнхий шинж байдал	32
3.3 Биеэ үнэлэлт	39
3.4 Эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ХДХВ өвчний талаарх мэдлэг	39
3.5 Согтууруулах ундаа ба мансууруулах бодисын хэрэглээ	52
3.6 Хүн худалдаалах гэмт хэргийн тухай мэдлэг, хандлага	53
3.7 Ирээдүйн зорилго	54
Бүлэг 4. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд	56
4.1 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тоо, насны бүлэг, дүүргээр, байршлаар	57

4.2	Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн ерөнхий шинж байдал	58
4.3	Бэлгийн мөлжлөгт өртөж буй байдал, шалтгаан	60
4.4	Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн талаарх нэмэлт мэдээлэл	63
4.5	Эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ХДХВ өвчний талаарх мэдлэг	65
4.6	Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ	66
4.7	Хүн худалдаалах гэмт хэргийн тухай мэдлэг, хандлага	67
4.8	Ирээдүйн зорилго	67
Бүлэг 5. Дүгнэлт, зөвлөмж		68
Хавсралт 1. Судалгааны түүврийн дизайн		74
Хавсралт 2. Үр дүнгийн хүснэгтүүд		82
Хавсралт 3. Асуулгын хуудас		96

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгааны бүлэг тус бүрт сонгогдсон ТАШН, судалгаанд хамрагдах хүний тоо	21
Хүснэгт 3.1.	Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлгээр, байршлаар	29
Хүснэгт 3.2.	Биеэ үнэлэгчид насны бүлгээр, дүүргээр, хувиар	30
Хүснэгт 3.3.	Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлгээр	31
Хүснэгт 3.4.	Биеэ үнэлэгчдийн боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар	32
Хүснэгт 3.5.	Биеэ үнэлэгчдийн гэрлэлтийн байдал, хүйсээр, дүнд эзлэх хувиар	35
Хүснэгт 3.6.	Биеэ үнэлэгчдийн ажил эрхлэлт, хүйсээр, дүнд эзлэх хувиар	38
Хүснэгт 3.7.	Биеэ үнэлэгчдийн биеэ үнэлж буй хугацаагаар, байршлаар, дүнд эзлэх хувиар	40
Хүснэгт 3.8.	Биеэ үнэлэгчдийн тоо, анх биеэ үнэлж эхэлсэн насны бүлгээр, байршлаар, дүнд эзлэх хувиар	41
Хүснэгт 3.9.	Биеэ үнэлэгчдийн анхны болон одоогийн үйлчлүүлэгчдээ олж авч буй байршил, хувиар	43
Хүснэгт 3.10.	Биеэ үнэлэгчдийн сарын орлого, хүйсээр, хувиар	44
Хүснэгт 3.11.	Бэлгийн харьцаанд анх ямар нөхцөлд, хэнтэй орж байсан байдал, хувиар	50
Хүснэгт 3.12.	Биеэ үнэлэгчид, бэлгийн харьцаанд голлон ордог хүнээр, насны бүлэг, хувиар	51
Хүснэгт 3.13.	Биеэ үнэлэгчдийн архины хэрэглээ, насны бүлэг, хувиар	53
Хүснэгт 4.1	Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн сургуулиас завсардсан шалтгаан, завсардсан ангиар	58
Хүснэгт 4.2	Бэлгийн мөлжлөгт өртөхөөс өмнө нь ямар нэгэн ажил эрхэлж байсан эсэх, дүүргээр	59
Хүснэгт 4.3	Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн анх бэлгийн харьцаанд орсон нөхцөл байдал, хувиар	66

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 3.1.	Биеэ үнэлэгчдийн байршил, хувиар	30
Зураг 3.2.	Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлэг, хүйсээр	31
Зураг 3.3.	Биеэ үнэлэгчдийн боловсролын түвшингийн бүтэц, дүнд эзлэх хувиар	32
Зураг 3.4.	Суралцагчид, сургуулийн төрөл, хувиар	33
Зураг 3.5.	Сургуулиас завсардсан биеэ үнэлэгчид, шалтгаан, хувиар	33
Зураг 3.6.	Биеэ үнэлэгчдийн одоогийн оршин сууж буй газраа бүртгүүлээгүй байгаа шалтгаан, хувиар	34
Зураг 3.7.	Шилжиж ирсэн биеэ үнэлэгчид, хамт ирсэн хүнээр, хувиар	34
Зураг 3.8.	Шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн шилжих болсон шалтгаан, хувиар	35
Зураг 3.9.	Гэр бүлийнхэнтэйгээ хэр ойлголцдог эсэх, хувиар	36
Зураг 3.10.	Биеэ үнэлэгчдийн өрхийн ам бүлийн тоо, хувиар	36
Зураг 3.11.	Гэр бүлийнхнээс нь учруулдаг дарамт, шахалтууд, хувиар	37
Зураг 3.12.	Гэр бүлийнхнээсээ тусдаа амьдардаг биеэ үнэлэгчид, хамт амьдардаг хүн, хувиар	37
Зураг 3.13.	Хүүхэдтэй биеэ үнэлэгчид, хүүхдийн тоогоор, хувиар	37
Зураг 3.14.	Одоо амьдарч буй орчин, хувиар	37
Зураг 3.15.	Анх ажил хийж эхэлсэн насны бүлэг, хувиар	39
Зураг 3.16.	Ажлаас гарсан шалтгаан, хувиар	39
Зураг 3.17.	Биеэ үнэлж буй хугацаа, хувиар	39
Зураг 3.18.	Биеэ анх үнэлж эхэлсэн насны бүлэг, хувиар	40
Зураг 3.19.	Биеэ үнэлж эхлэхэд анх уруу татсан хүн, хувиар	41
Зураг 3.20.	Анх хүчиндсэн хүн, хувиар	41
Зураг 3.21.	Анх үйлчлүүлэгчээ олж авч байсан газар, хувиар	42
Зураг 3.22.	Одоо үйлчлүүлэгчээ олж авч байгаа газар, хувиар	42
Зураг 3.23.	Биеэ үнэлэгчдийн биеэ үнэлж байсан улс, орнууд, хувиар	44
Зураг 3.24.	Биеэ үнэлэгчдийг гадаадад гарахад нь тусалсан хүн, хувиар	44
Зураг 3.25.	Биеэ үнэлэгчдийн орлогын зарцуулалт, хувиар	45
Зураг 3.26.	Охид эмэгтэйчүүдийг олж өгөөч гэсэн, санал тавьж байсан хүн, хувиар	46
Зураг 3.27.	Үйлчлүүлж байсан гадаадын хүн, хувиар	46

Зураг 3.28. Зуучлагчтай биеэ үнэлэгчдийн насны бүлэг, хувиар	47
Зураг 3.29. Зуучлагчид, насны бүлгээр, хувиар	47
Зураг 3.30. Биеэ үнэлэгчдэд зуучлагчдаас үзүүлж буй туслалцаа, хувиар	48
Зураг 3.31. Үйлчлүүлэгчдийн зүгээс үзүүлдэг дарамт, шахалт, хувиар	49
Зураг 3.32. Зуучлагчдын зүгээс үзүүлдэг, дарамт, шахалт, хувиар	49
Зураг 3.33. Биеэ үнэлэгчид, хэдэн удаа үр хөндүүлж байснаар, хувиар	50
Зураг 3.34. БЗДХ-ын шинжилгээнд сүүлд хамрагдаж байсан хугацаа, хувиар	52
Зураг 3.35. БЗДХ тусч байсан биеэ үнэлэгч, эмчлүүлж байсан эсэхээр, хувиар	52
Зураг 3.36. Биеэ үнэлэгчдийн цаашдын зорилго, хувиар	54
Зураг 3.37. Биеэ үнэлэгчдийн цаашид биеэ үнэлье гэж бодож буй хугацаа, хувиар	54
Зураг 4.1 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд, дүүргээр, хувиар	57
Зураг 4.2 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд, байршлаар, хувиар	57
Зураг 4.3 Бэлгийн мөлжлөгт өртсөн охид, гэр бүлийнхэнтэйгээ хэр ойлголцдог талаар, хувиар	59
Зураг 4.4 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн амьдардаг газар, хувиар	69
Зураг 4.5 Үйлчлүүлэгчээ голдуу олж авдаг газар, хувиар	60
Зураг 4.6 Бэлгийн мөлжлөгт өртөх болсон анхны шалтгаан, хувиар	60
Зураг 4.7 Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын сарын дундаж орлого, хувиар	61
Зураг 4.8 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг байрлуулдаг газар, хувиар	63
Зураг 4.9 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн насны бүтэц, хувиар	63
Зураг 4.10 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг зуучилдаг хүмүүс, хувиар	64
Зураг 4.11 Бэлгийн мөлжлөгт өртөж буй байдал, хувиар	64
Зураг 4.12 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг үйлчлүүлэгчид зуучилдаг байдал, хувиар	65

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХС	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
АХС	Ажиллах хүчний судалгаа
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТХШН	Түүврийн хоёр дах шатны нэгж
ХХУОУХ	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
НЦГ	Нийслэлийн цагдаагийн газар
ОНХА	Олон нийттэй харилцах алба
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДОХ	Дархлал олдмолын хомсдол
ХДХВ	Хүний дархлал хомсдлын вирус
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс

Бүлэг 1

ЕРӨНХИЙ ТОЙМ

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

1.1 Судалгааны зорилго, ач холбогдол

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (ХХС)”-г Ажиллах хүчний судалгаа (АХС)-ны хавсарга судалгаа болгон 2 удаа (2002-2003, 2006-2007) явуулсан бөгөөд эдгээр судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн санг бүрдүүлсэн билээ. Гэхдээ энэхүү судалгаанууд нь өрхөд суурилсан судалгаа байсан тул хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, түүний дотор хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх мэдээлэл цуглуулах боломжгүй байсан болно.

Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, золиос болох эрсдэл их байдагтай холбоотойгоор бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад шаардлагатай суурь тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай болоод байна.

Түүнчлэн насанд хүрэгчдийн биеэ үнэлэлт, хүүхдийн бэлгийн мөлжлөгийн өнөөгийн байдлын талаар зөв, бодитой мэдээлэл өгөх нийгмийн шаардлага ч урган гарч байна.

Судалгааны гол зорилго нь:

- Улаанбаатар хотод бэлгийн мөлжлөгт өртөж байгаа хүүхэд болон биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн тоог гаргах;
- Охид, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөгт өртсөн болон биеэ үнэлж байгаа шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох;
- Хүүхэд болон насанд хүрэгчид биеэ үнэлж байгаа үндсэн шалтгаан, үр дагаварт үнэлгээ өгөх;
- Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийн нийгэм-эдийн засгийн байдлыг тодорхойлох;
- Биеэ үнэлэх явдлаа зогсоохыг хүсэвч чадахгүй байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийн тоог гаргах;

- Хүүхдийн бэлгийн мөлжлөгийг таслан зогсоход чиглэсэн зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (ХХУОУХ)-ийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын хэмжээнд зохион байгуулж явуулав. Судалгааг явуулснаар дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Өрхийн түүвэр судалгаагаар тооцох боломжгүй хүүхдийн хөдөлмөрийн нэн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг болох хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх мэдээлэл, түүнийг цуглуулах арга зүйг бий болгох;
- Үндэсний түвшний зохицуулалтын механизм (тухайлбал “Хүн худалдах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохицуулах үндэсний зөвлөлийн гишүүд), Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх Үндэсний зохицуулах хороо, нийслэлийн түвшний холбогдох төр, төрийн бус байгууллагууд, эзэд, үйлдвэрчний байгууллагуудыг мэдээллээр хангах, ойлголтыг нь дээшлүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний үндэслэлийг сайжруулах;
- Хүүхдийн бэлгийн мөлжлөгийг устгахад чиглэсэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, боловсронгуй болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг дэмжих;
- Хүүхдийн мөлжлөг, нийгмийн сөрөг үзэгдлийн эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж буй хууль сахиулах болон нийгмийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих;
- Хүүхэд хамгааллын үзүүлэлтүүдийг гаргахад дэмжлэг үзүүлэх;
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг судлах судалгааны арга зүйг боловсронгуй болгох зэрэг болно.

1.2 Тайлангийн бүтэц, агуулга

Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгааны үр дүнгийн тайлан нь дараах 5 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

Бүлэг 1. Ерөнхий тойм

Бүлэг 2. Судалгааны арга зүй, зохион байгуулалт

Бүлэг 3. Биеэ үнэлэгчид

Бүлэг 4. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд

Бүлэг 5. Дүгнэлт, зөвлөмж

Тайлангийн 1-р бүлэгт судалгааны зорилго, ач холбогдол, тайлангийн бүтэц, агуулга болон судалгааны товч үр дүн, Бүлэг 2-т судалгааны арга зүй, зохион байгуулалт, судалгааны давуу болон сул талууд, судалгааны мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл бэрхшээл, даван туулсан байдал, сургамж, Бүлэг 3-т биеэ үнэлэгчдийн тоо, тэдний ерөнхий шинж байдал, биеэ үнэлэлт, эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ХДХВ өвчин болон хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг, согтууруулах ундаа болон мансууруулах бодисын хэрэглээ, ирээдүйн зорилгын талаар, Бүлэг 4-т бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тоо, насны бүлэг, байршлаар, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн ерөнхий шинж байдал, бэлгийн мөлжлөгт өртөж буй байдал, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхлийн талаарх нэмэлт мэдээлэл, тэдний эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ХДХВ өвчин болон хүний наймааны талаарх мэдлэг, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ болон ирээдүйн зорилгын талаар, Бүлэг 5-д судалгааны үр дүнгээр гарч буй дүгнэлт, зөвлөмжийг багтаасан болно.

1.3 Судалгааны товч дүн

Судалгаанд 22.8 мянган хүн хамрагдсаны 20.5 хувь буюу 4683 нь биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд байна гэсэн дүн гарлаа. Үүнээс гадна энэхүү судалгаанд хамрагдсан гудамж, талбайд зогсож биеэ үнэлж буй хүмүүсээс бэлгийн мөлжлөгт өртөж буй хүүхдийн талаарх нэмэлт мэдээллийг цуглуулсан бөгөөд энэ мэдээллийн үндсэн дээр Улаанбаатар хотын хэмжээнд бэлгийн мөлжлөгт өртөж буй 140 гаруй хүүхэд байна гэсэн тооцоо гарсан болно. Нэмэлт мэдээллийн дүнгээс харахад бэлгийн мөлжлөгт өртөж буй хүүхдүүдийг гудамж, талбайд зогсоодоггүй, зуучлагчид үйлчлүүлэгчдэд хүргэж өгдөгөөс шалтгаалан судалгааны дүнгээр бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тоо бага гарахад нөлөөлсөн байх талтай. Энэ хэсэгт судалгааны дүнгээр гарсан биеэ үнэлэгчид, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн талаар цуглуулсан нэмэлт мэдээллийн дүнг танилцуулах болно.

- Судалгааны дүнгээр нийслэлийн хэмжээнд биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тоо 4683 байгааг хүйсээр нь авч үзвэл 85.0 хувь буюу 4643 нь эмэгтэйчүүд, охид байна.
- Нийт биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн 13.6 хувь нь гудамж, талбайд зогсож биеэ үнэлж байна.
- Биеэ үнэлж буй болон бэлгийн мөлжлөгт өртсөн арван хүний зургаа нь үйлчлүүлэгчээ 30 ба түүнээс дээш суудалтай караоке, баар, цэнгээний газраас, арван хүний нэг нь саун, массажны газруудаас олж авдаг байна.
- Судалгааны дүнгээр бараг арван хүний нэг нь буюу 43 хүүхэд бэлгийн мөлжлөгт өртөж байна гэсэн дүн гарлаа.

Биеэ үнэлэгчид

- Судалгааны тархаалтын тооцоогоор нийслэлийн хэмжээнд насанд хүрсэн 4640 биеэ үнэлэгч байгаагийн 99.1 хувь нь эмэгтэйчүүд, 0.9 хувь нь эрэгтэйчүүд байна.
- Нийт биеэ үнэлэгчдийн 13.6 хувь нь гудамж, талбайд зогсож биеэ үнэлдэг бол 86.4 хувь нь үйлчлүүлэгчээ караоке, баар, цэнгээний газар, саун, массажны газруудаас олж авдаг байна.
- Биеэ үнэлэгчдийн дундаж нас нь 34 байгаа бөгөөд хамгийн ахмад нь 53 настай, харин хоёр биеэ үнэлэгч тутмын нэг нь 21-29 насныхан байна.
- Биеэ үнэлэгч таван хүн тутмын гурав нь бүрэн дунд боловсролтой, нэг нь дээд боловсролтой байна. Харин бага болон боловсролгүй хүний нийт дүнд эзлэх хувь 2.6 байна.
- Биеэ үнэлэгчдийн 17.0 хувь нь суралцаж байгаа бөгөөд сургуулийн төрлөөр нь авч үзвэл: их дээд сургуульд 79.0 хувь нь, 13.2 хувь нь коллежид, 7.8 хувь нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд сурч байна.
- Сургуульд суралцдаггүй биеэ үнэлэгчдийн 52.4 хувь нь сургууль завсардсан бөгөөд тэдний 60.0 хувь нь ерөнхий боловсролын сургуулиас, 39.6 хувь нь их, дээд сургуульд сурч байгаад гарчээ. Сургууль завсардсаны гол шалтгаан нь санхүүгийн бэрхшээл гэж хариулсан байна.

- Судалгаанд хамрагдагчдын 57.5 хувь нь гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдардаг байна.
- Нийт биеэ үнэлэгчдийн 47.3 хувь буюу 2193 нь хүүхэдтэй байна. Хүүхэдтэй биеэ үнэлэгчдийн 76.2 хувь нь 1-2 хүүхэдтэй, 23.8 хувь нь гурав ба түүнээс дээш хүүхэдтэй байв. Хүүхэдтэй биеэ үнэлэгч хоёр хүний нэг нь 5 хүртэлх насны хүүхэдтэй байна.
- Биеэ үнэлэгч гурван хүний нэг нь өөрийн гэсэн амьдрах сууцтай мөн биеэ үнэлэхээс гадна ямар нэгэн цалин хөлстэй ажил эрхэлж байна.
- Биеэ үнэлэх болсон үндсэн шалтгаанд мөнгө олох явдал байгаа бөгөөд дараа нь зөвхөн сургалтын төлбөрөө олох, гэр бүлээ тэжээх гэж хариулсан байна.
- Биеэ үнэлэгчдийн бараг тал хувь нь 1-3 жил биеэ үнэлж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн дээд тал нь 26 жил, эрэгтэйчүүдийн дээд тал нь 12 жил биеэ үнэлж байна гэсэн дүн гарлаа.
- Биеэ үнэлэгч хоёр хүний нэг нь биеэ үнэлэхээсээ өмнө хүчиндүүлсэн байна.
- Биеэ үнэлэгч нарын үйлчлүүлэгчээ олж авдаг анхны болон одоогийн газруудыг харьцуулж үзэхэд үйлчлүүлэгчийн дуудлагаар (1.1 пункт) болон шөнийн клуб, баар цэнгээний газруудаас (18.1 пункт) үйлчлэгчээ олж авч байгаа нь нэмэгдсэн байна.
- Нийт биеэ үнэлэгчдийн 4.9 хувь нь гадаадад биеэ үнэлж байсан бөгөөд тэдний 71.7 хувь нь БНХАУ-д, 7.2 хувь нь Сингапурт, 6.7 хувь нь ОХУ-д, 4.9 хувь нь Японд, 4.9 хувь нь Макаод, 4.6 хувь нь БНСУ-д гэж хариулсан байна.
- Биеэ үнэлэгчдийн 99.4 хувь нь хөлсөө үйлчлүүлэгчдээс бэлэн мөнгөөр авдаг байхад үлдсэн 0.6 хувь нь мөнгөн бус хэлбэрээр авдаг байна.
- Биеэ үнэлэгчдийн сарын дундаж орлого 200.0-500.0 мянган төгрөг байна.
- Тэд өдөрт дунджаар 3 хүнд үйлчилдэг бөгөөд үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 34, хамгийн залуу үйлчлүүлэгч нь 15 настай, хамгийн ахмад нь 80 настай хүн байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд

- Нийт 4683 биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд байгаагийн 0.9 хувь буюу 43 хүүхэд нь 18 хүртэлх насны буюу бэлгийн мөлжлөгт өртсөн охидууд байна.
- Эдгээр охидын хоёр нь 15 настай, бусад нь 17 настай байв.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 14.0 хувь нь одоогоор коллежид суралцагчид, 46.5 хувь нь бага боловсролтой, 39.5 хувь нь боловсролгүй хүүхдүүд байна.
- Эдгээр охидын 23.3 хувь нь одоогоор гэр бүлийнхэнтэйгээ, 34.9 хувь нь ганцаараа, 34.9 хувь нь найзуудтайгаа, 6.9 хувь нь найз залуутайгаа амьдардаг байна.
- Харин бэлгийн мөлжлөгт өртсөн дөрвөн охидын гурав нь гэр бүлийнхэнтэйгээ ойлголцож чаддаггүй, гурван охидын нэг нь гэр бүлийнхэнтэйгээ байхад сэтгэл зүйн дарамт/заналхийлэлд өртдөг, зодуулдаг, сургуульд суралцуулдаггүй, гэрээс хөөдөг гэж хариулсан байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн арван хүүхдийн тав нь мөнгө олохоор, хоёр нь бусдад тавьсан өрөө төлөхөөр, хоёр нь гэр бүлээ тэжээхээр анх бэлгийн харьцаанд орсон байна.
- Нийт охидын 4.7 хувь нь 14 настайдаа, харин 95.3 хувь нь 16 настайдаа анх бэлгийн мөлжлөгт өртсөн байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 44.2 хувь нь хүчиндүүлж байсан бөгөөд хүчиндсэн хүн нь голдуу /90 хувь нь/ хойд эцэг нь байжээ.
- Гэр бүлийнхэн бэлгийн мөлжлөгт өртсөн охидыг одоогоор нь биеэ үнэлж байгааг мэддэггүй байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн таван охидын дөрөв нь 30 ба түүнээс дээш суудалтай караоке, баар, цэнгээний газраас үйлчлүүлэгчээ олж авдаг байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын бараг арван хүүхдийн нэг нь зуучлагчтай болсон ба зуучлагчаараа дамжуулж хөлсөө авдаг байна. Зуучлагчтай охидууд бүгд зуучлагчиддаа өр, зээлтэй байна.

- Охидын зуучлагчид нь 21-30 насны эмэгтэй хүмүүс байдаг байна. Тэднийг өмнө нь таньдаг байсан, хуурай эгч байцгаасан болон найзаараа дамжуулж танилцаж байжээ.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 7.0 хувь нь биеэ үнэлж байхдаа үйлчлүүлэгчдээс болж гэмтэл, бэртэл авч байсан байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн 34.9 хувь нь 13 настайдаа, 18.6 хувь нь 14 настайдаа, 46.5 хувь нь 16 настайдаа анх бэлгийн харьцаанд оржээ.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 34.9 хувь бэлгийн замаар дамжих халдварт өвчин туссан үед илрэх шинж тэмдгүүдийг мэднэ, 4.7 хувь бага зэрэг мэднэ, 60.5 хувь нь мэдэхгүй гэсэн нь энэ талаарх мэдлэг, ойлголт дутмаг байгааг харуулж байна.
- Охидын талаас илүү хувь нь БЗДХ/ДОХ/ХДХВ-ын шинжилгээ огт өгч байгаагүй, 60 гаруй хувь нь БЗДХ тусч байгаагүй бол, харин 34.9 хувь нь энэ төрлийн өвчин тусч эмчилгээ хийлгэж байсан байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн талаарх нэмэлт мэдээлэл

- Нэмэлт мэдээллийн үндсэн дээр Улаанбаатар хотын хэмжээнд бэлгийн мөлжлөгт өртөж буй 140 гаруй хүүхэд байна гэсэн дүн гарч байна.
- Зуучлагчид хүүхдүүдийг ихэнхидээ зочид буудал (41.1 хувь), түрээсийн сууц (18.4 хувь) болон өөрсдийн гэрт(15.2 хувь) байлгадаг байна. Жишээлбэл: Салхит, Ханын материал, Дарь эх, Таван шар, Алтан-Өлгий, Хайлааст, 7 буудал гэх мэт. Гэхдээ байрлалаа ойр ойрхон сольдог гэж байлаа.
- Нэмэлт мэдээллээр авч тооцсон бэлгийн мөлжлөгт өртөж буй хүүхдүүдийн хамгийн бага нь 13 настай хүүхдүүд байна.
- Зуучлагчид нь голдуу урьд нь биеэ үнэлэгч байсан эмэгтэйчүүд (Бүргэд, Сорвит, Онон, Мийгаа, Цоомоо, Хар Туяа, Равдангийн Оюунаа, Болдмаа, Барзаак Туяа, бүдүүн Тамираа, шулга Сараа, Бялзуухай, Нандиа, 49.. г.м), мөн нэг гэр бүлийн (Оюунаа-Манлай, Жижгээ-Ганаа г.м) хүмүүс байдаг байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн биеийг үнэлүүлдэг хүмүүсийн 40 орчим хувь нь охидыг дарамталдаг, 18.4 хувь нь охидыг зоддог, мөн зарим нь өөрсдийн

гэсэн бүлэглэлтэй бөгөөд зугтсан, эсэргүүцсэн охидыг тэднээр зодуулах эсвэл гэмт хэргийн хүрээнийхэнд өгч явуулан зодуулж, дарамтлуулдаг гэсэн бол, 5 орчим хувь нь мөрдөн мөшгидөг, гэрээс нь очоод дарамтлаад аваад ирдэг гэж хэлж байв.

- Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг дуудлагаар үйлчлүүлэгчид хүргэж өгөхөөс гадна өдөр бүр өөр машин хөлсөлж, хүүхдүүдийг дагуулж явдаг гэж байв.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг хаанаас олж авдаг талаар асуухад 40 гаруй хувь нь хаанаас олдгийг сайн мэдэхгүй байна гэсэн бол 27.3 хувь нь гудамжнаас, 11.6 хувь нь баарнаас, 5.8 хувь нь гэрээсээ явсан хүүхдүүдийг, 3.3 хувь нь найз нөхдөөр нь дамжуулж, 2.5 хувь нь TV чатаар дамжуулж олж авдаг гэсэн байна.

Бүлэг 2

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Судалгааны хамрах хүрээ

Судалгааг зөвхөн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийг хамруулан хүн ам багатай, судалгааны зорилтот бүлгийн хүмүүсийн талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй байгаа Багахангай дүүргээс бусад 8 дүүрэгт хийсэн.

Судалгааны зорилтот хүн ам нь 18-аас доош насны бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд болон насанд хүрсэн биеэ үнэлэгчид юм. Эдгээр хүмүүс байж болох эрсдэлтэй газрууд гэдэгт: (1) гудамж, талбай, (2) караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб, (3) массаж, сауны газруудыг хамруулсан. Караоке/баар/цэнгээний газар/шөнийн клубуудыг суудлын тоо буюу багтаамжаас нь хамааруулан 30 хүртэл суудалтай “Жижиг”, 30 ба түүнээс дээш суудалтай “Том” гэж 2 хуваасан болно.

Түүврийн хүрээг дараах байршлаар 6 бүлэг үүсгэн бүрдүүлсэн. Үүнд:

- 1) Гудамжны биеэ үнэлэгчид;
- 2) Албан ёсны бүртгэлтэй “ЖИЖИГ” буюу 30 хүртэл суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;
- 3) Албан ёсны бүртгэлтэй “ТОМ” буюу 30 ба түүнээс дээш суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;
- 4) Албан ёсны бүртгэлгүй “ЖИЖИГ” буюу 30 хүртэл суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;
- 5) Албан ёсны бүртгэлгүй “ТОМ” буюу 30 ба түүнээс дээш суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;
- 6) Массаж, сауны газрууд;

2.2 Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийг 2 шатат энгийн бүлэглэсэн түүврийн аргыг ашиглан хийсэн. Эхний шатанд биеэ үнэлэгчид байж болох эрсдэлтэй газрын байршлын ангиллын дагуух 6 бүлгээс түүвэрлэлт хийгдсэн. Түүврийн анхан шатны нэгж (ТАШН) нь гудамж, талбайн зогсоол, караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб, массаж, сауны

газрууд байна. Хоёрдах шатанд 6 бүлгээс сонгогдсон ТАШН-ээс судалгаанд хамрагдах хүмүүсийг сонгоно.

Түүврийн бүлэг

Бүлэг 1- Гудамж, талбайн зогсоолууд;

Бүлэг 2 - Албан ёсны бүртгэлтэй “ЖИЖИГ” буюу 30 хүртэл суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;

Бүлэг 3 - Албан ёсны бүртгэлтэй “ТОМ” буюу 30 ба түүнээс дээш суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;

Бүлэг 4 - Албан ёсны бүртгэлгүй “ЖИЖИГ” буюу 30 хүртэл суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;

Бүлэг 5 - Албан ёсны бүртгэлгүй “ТОМ” буюу 30 ба түүнээс дээш суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;

Бүлэг 6 - Массаж, сауны газрууд

Түүврийн анхан шатны нэгжүүд нь:

- Бүлэг 1-ийн хувьд гудамж, талбайн зогсоол,
- Бүлэг 2-5-ын хувьд караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб,
- Бүлэг 6-гийн хувьд массаж, саун.

Бүлэг тус бүрээс энгийн санамсаргүй түүврийн аргаар ТАШН-ийг сонгосон. Харин түүврийн хоёр дах шатны нэгж буюу судалгаанд хамрагдах хариулагчийн тоог бүлэг бүрт харилцан адилгүйгээр хуваарилсан (Түүвэрлэлтийн арга зүйг хавсралт 1-ээс үзнэ үү).

Хүснэгт 1

Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгааны бүлэг тус бүрээс сонгогдсон ТАШН, судалгаанд хамрагдах хүний тоо

Бүлгийн дугаар	Байршил	Эх олонлогийн хэмжээ	Сонгогдсон ТАШН-ийн тоо	Нэг нэгжээс хамрагдах хүний тоо	Судалгаанд хамрагдах хүний тоо
1	Гудамжны биеэ үнэлэгчид*	21	21	-	254
2	Албан ёсны бүртгэлтэй “ЖИЖИГ” буюу 30 хүртэл суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб	189	39	8	312
3	Албан ёсны бүртгэлтэй “ТОМ” буюу 30 ба түүнээс дээш суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб	439	70	12	840
4	Албан ёсны бүртгэлгүй “ЖИЖИГ” буюу 30 хүртэл суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб	46	32	8	256
5	Албан ёсны бүртгэлгүй “ТОМ” буюу 30 ба түүнээс дээш суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб	63	27	12	324
6	Массаж, сауны газрууд	149	34	8	272
ДҮН		907	223		2258

* Гудамж, талбайн 21 зогсоол дээр нийт 640 хүн бүртгэлтэй байгаагаас 254 нь сонгогдсон болно.

2.3 Судалгааны асуулгын хуудас

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан ОУХБ-ын зөвлөмж, аргачлал арга зүй болон энэ төрлийн судалгаа явуулсан гадаад, дотоодын байгууллагуудын туршлагыг судалсны үндсэн дээр судалгааны асуулгыг боловсруулав.

Судалгааны асуулга нь судалгааны зорилгод нийцүүлэн охид, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөгт өртсөн болон биеэ үнэлэх болсон шалтгаан, үр дагавар, цаашдын бодол, хандлагыг судлах 12 бүлэг бүхий 106 асуултаас бүрдэнэ. Үүнд:

А: Лавлагааны хэсэг

Бүлэг I. Ерөнхий мэдээлэл

Бүлэг II. Шилжих хөдөлгөөн

Бүлэг III. Гэр бүлийн байдал

Бүлэг IV. Тухайн үеийн болон өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт

Бүлэг V. Эрүүл мэнд ба БЗДХ болон ДОХ/ХДХВ өвчний талаарх мэдлэг

Бүлэг VI. Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ

Бүлэг VII. Чөлөөт цаг

Бүлэг VIII. Биеэ үнэлэлт ба бэлгийн мөлжлөг

Бүлэг IX. Эрүүл мэнд болон ажлын нөхцөл байдал

Бүлэг X. Үйлчлүүлэгчдийн байдал

Бүлэг XII. Ирээдүйн талаарх төсөөлөл

Бүлэг XII. Хүн худалдаалах гэмт хэргийн тухай мэдлэг

2.4 Туршилтын судалгаа

Асуулгын эхний хувилбарыг боловсруулсны дараа асуулгын зохиомж, бүтэц, агуулгыг хянах зорилгоор туршилтын судалгааг судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэх “Хүйсийн тэгш эрхийн төв”-ийн судлаачдын баг судалгааны хамрах хүрээний жагсаалтанд байгаа 5 гудамж, талбай дээр зогсож биеэ үнэлж буй 15 эмэгтэй, баар, цэнгээний 10 газарт үйлчлүүлж буй 20 хүнийг хамруулан явуулсан. Туршилтын судалгааны дүнд үндэслэн асуулгыг дахин хянаж, асуулгын найруулга, асуултуудын хоорондын уялдаа холбоог сайжруулж, зарим шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг тусган асуулгыг боловсронгуй болгосон.

2.5 Судалгааны зохион байгуулалт

Судалгааны ажлын хэсгийг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр ҮСХ-н дээр байгуулж, судалгааг зохион байгуулан явуулах, хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. ҮСХ нь судалгааны үйл ажиллагаанд мэргэжил,

арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр оролцож, судалгааны асуулга, заавар боловсруулах, судалгааны түүврийн зохиомжийг гаргаж, түүвэр хийх, судалгааны ахлагч, судлаач нарын сургалт зохион байгуулах, мэдээлэл боловсруулах, үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийх, ажлын хэсгийн гишүүдийн хамт үр дүнгийн тайлан бичих, тархаах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв. Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг бэлгийн мөлжлөгт өртсөн болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд туслах, ердийн амьдралд оруулж нийгэмшүүлэх чиглэлээр ажилладаг “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ хариуцан хийсэн болно. Харин ОУХБ/ХХУОУХ-ийн зүгээс судалгааны асуулгын хуудас боловсруулах, түүвэр хийх болон судалгааны үйл ажиллагаанд шаардлагатай зөвлөхийн үйлчилгээ үзүүлэв.

2.6 Судалгааны ахлагч, судлаач нарын сургалт

Судалгааны ажлыг чанартай сайн гүйцэтгэх, шаардлага хангасан мэдээлэл цуглуулах үүднээс судалгааны ахлагч болон судлаач нарт зориулсан сургалтыг зохион байгуулж явуулсан. Сургалтаар судалгааны үндсэн зорилго, ач холбогдол, судалгааны арга зүй болон судалгаанд хэрэглэгдэж буй ойлголт, тодорхойлолтуудыг тайлбарлан, асуулгын хуудсыг хэрхэн нөхөх тухай дэлгэрэнгүй зааварчилгааг өгч, асуулга нөхөхөд зориулсан гарын авлагыг бэлтгэсэн. Мөн үйлчилгээний газарт үйлчлүүлэгчдээс судалгаанд хамрагдах оролцогчдыг сонгох шалгуур үзүүлэлтүүд, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн талаар нэмэлт мэдээлэл цуглуулах болон судалгаа авахад анхаарах ёс зүй, аюулгүй байдал, насанд хүрээгүй хохирогчдод туслалцаа хэрхэн үзүүлэх талаар сургалтын явцад онцлон анхааруулсан болно.

2.7 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг “Хүйсийн тэгш эрхийн төв” удирдан зохион байгуулж, мэргэшсэн 8 төрийн бус байгууллага хамтран явуулсан болно. Судалгааны багийн ахлагчийн удирдлаган дор багууд сонгогдсон гудамж, талбай, баар, цэнгээний газар, саун массажны газарт очиж өгөгдсөн зааварчилгааны дагуу судалгаанд хамрагдагчдыг сонгон нэг бүрчлэн уулзаж, ярилцлага авах замаар мэдээллээ цуглуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2010 оны 3 дугаар сарын 4-24-ний хооронд хийж гүйцэтгэсэн. Мэдээлэл цуглуулах явцад тус төвөөс хяналтын шалгалт

хийж гарсан ололт, дутагдалтай тухай бүр нь танилцаж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

Судалгааны асуулгыг шалгаж, хүлээн авч мэдээллийг компьютерт шивж оруулах, бүрдэлтийг хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСХ-нд хийж гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSPro3.1 багц програмыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг боловсруулж, холбогдох хүснэгтүүдийг SPSS13.0 програмыг тус тус ашиглан улмаар статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянан, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулсан болно.

2.8 Судалгааны давуу болон сул талууд

Судлаачид энэхүү судалгаа нь цаг үе олсон, аргачлал болон зохион байгуулалтын хувьд сайн байлаа гэдгийг илэрхийлж байсан.

Судалгааны давуу тал:

- Судалгаанд олон байгууллагын мэргэшсэн ажилтнуудыг оролцуулж, баг тус бүрт нэг цагдаагийн ажилтан ажилласан нь судлаачдын аюулгүй байдлыг хангахаас гадна мэдээллийг бодитой, үнэн зөв цуглуулах нөхцлийг бүрдүүлж өгч байснаараа давуу талтай байв.
- Судлаач нартай ёс зүйн гэрээ байгуулсан нь судалгааны явцад гарч болох алдаанаас урьдчилан сэргийлж чадсан.
- Судалгааны багт Нийслэлийн цагдаагийн газар (НЦГ)-ын Олон нийттэй харилцах алба (ОНХА)-ны албан хаагчдыг оролцуулсан нь энэхүү судалгааг хийхэд гарсан хүндрэл бэрхшээлийг даван туулахад ихээхэн хувь нэмрээ оруулсан гэж үзэж байна.
- Мөн багаар ажиллах арга туршлагад суралцаж, хамтаар асуудлыг шийдэж байсан нь судалгааны үр дүнд эерэгээр нөлөөлсөн.
- Судалгаанд хамрагдсан хүмүүст урамшуулал олгосон нь асуулга болон мэдээлэл цуглуулах ажлыг хөнгөвчилснөөс гадна тэд нараас бодит мэдээллийг авахад чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Судалгааны сул тал:

- Судалгааны багийн зарим гишүүд нь мэргэжлийн судлаачид биш байсан тул бага зэрэг хүндрэлтэй байсан.
- Судалгааны мэдээлэл цуглуулахад улирлын хувьд маш тааламжгүй байсан. Оройдоо гадаа -20 хэмээс дээш хүйтэнтэй байсан тул гудамж, талбайгаас судалгаа авахад хүндрэлтэй байсан. Тиймээс нэг баг 2-3 машин хөлсөлж, ярилцагчаас машин дотор судалгааг авч байв.
- Асуулга хэт олон хуудастай байснаас судалгаа өгөгчийг залхаах, ядраах хандлага ажиглагдаж байв.

2.9 Мэдээлэл цуглуулах явцад тохиолдсон хүндрэл бэрхшээл, даван туулсан байдал, сургамж

- Олон байгууллагын ажилтнууд оролцсон учир цагийг зохицуулах асуудал хүндрэлтэй байсан. Тиймээс баг тус бүрт ахлагч нарыг томилж, багийн дотоод зохион байгуулалтыг хийлгэн, бүх албан байгууллагад оройн цагаар ажиллах боломжоор хангаж өгөх тухай албан хүсэлт явуулж зохицуулсан.
- Судалгааны явцад зарим нэгж дээр судалгаа өгөхийг эсэргүүцэх, уурлах зэрэг асуудлууд гарч байсан. Иймээс тус судалгааны түүвэрт сонгогдсон аж ахуйн нэгж, байгууллагад хандсан Цагдаагийн ерөнхий газар болон Үндэсний статистикийн хорооны тамга, тэмдэгтэй албан бичгийг судлаач нарын багт өгсөн нь тухайн газруудад судалгааны үйл ажиллагааг явуулахад хялбар болгосон.
- Сонгогдсон түүврийн анхан шатны нэгжээс зарим шөнийн клуб, баар цэнгээний болон сауны газрууд татан буугдсан, нэр хаягаа өөрчилсөн зэргээс шалтгаалан байршлыг тогтоох, эрж хайхад нилээд хугацаа алдаж, хүндрэл учруулж байв. Холбогдох байгууллагуудаас тодруулахад ихэнх үйлчилгээний газрууд түрээсээр ажилладгаас шинэ орсон түрээслэгч нь нэрээ өөрчилдөг байна.
- Шөнийн клуб, баар цэнгээний газруудаар явж, үйлчлүүлэгчидтэй нь ярилцлага хийж асуулга авахад хүндрэлтэй байсан. Учир нь дуу чимээ ихтэй орчинд уг судалгааны 5,6,7,8-р бүлгийн асуулгыг авахад судалгаанд оролцогчийг эвгүй байдалд оруулж байгаа нь ажиглагдаж байсан.

- Мөн олон нийтийн нүдэн дээр ил задгай талбайд ширээнүүдээ засаж байрлуулсан газрууд нилээдгүй байлаа. Ийм тохиолдолд судалгаанд оролцогчийн зүгээс бусдын анхаарлыг татахгүйг хичээх, биеэ барих, асуултыг хайхрахгүй өнгөрөх хандлагууд гарч байсан.
- Албан ёсны бүртгэлтэй болон бүртгэлгүй 30 хүртэлх суудалтай зарим газруудаар ороход үйлчлүүлэгчдийн тоо цөөн учраас сонгох боломжгүй тохиолдлууд нилээд гарсан төдийгүй нэг газартаа олон удаа ирж, очих шаардлага гарч байв.
- Үйлчилгээний газарт үйлчлүүлж байгаа залуу охид, эмэгтэйчүүд телевизийн нэвтрүүлэг байх вий, нууц камертай байх вий гэх мэтээр болгоомжлох тохиолдлууд гарч байсан. Судлаачид судалгааныхаа ач холбогдлын талаар тайлбарлаж, судалгаа өгөгч судлаач хоёрын хооронд итгэлцлийг бий болгож, асуулгаа бүрэн авч чадаж байсан.
- Цагдаагийн байгууллага, ТББ-ууд биеэ үнэлэгчдийн талаар нэгдсэн тоо мэдээ байдаггүйгээс бие биенийхээ тоо мэдээг үгүйсгэх хандлагатай байдаг. Харин хамтарч ажилласнаараа цаашид хүлээн зөвшөөрөгдөх нэгдсэн тоо мэдээтэй болсон гэж үзэж байна.

Бүлэг 3

БИЕЭ ҮНЭЛЭГЧИД

БҮЛЭГ 3. БИЕЭ ҮНЭЛЭГЧИД

Энэ бүлэгт биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгааны цуглуулсан мэдээлэл, түүн дээр үндэслэн тооцсон судалгааны үр дүнг танилцуулж байна. Улаанбаатар хотын найман дүүргийн гудамж, талбай болон үйлчилгээний газарт хийсэн судалгааны тархаалтын тооцоогоор 22.8 мянган хүн хамрагдсны 20.5 хувь буюу 4683 нь биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд байгаагийн 99.1 хувь нь эмэгтэйчүүд, 0.9 хувь нь эрэгтэйчүүд байна.

3.1 Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлэг, дүүргээр, байршлаар

Судалгааны дүнгээр нийт 4683 биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд байгаагийн 99.1 хувь буюу 4640 хүн нь насанд хүрэгчид буюу биеэ үнэлэгчид байна. Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд гудамж, талбайд зогсдог, караоке, баар, цэнгээний газруудаар үйлчлүүлж буй иргэд, саун, массажны газар ажиллагчид болон үйлчлүүлэгчид гэсэн байршлаар ялгарч байгаа бөгөөд судалгаагаар илэрсэн нийт 4.6 мянган биеэ үнэлэгчдийн 13.6 хувь нь гудамж, талбайд, 86.4 хувь нь үйлчилгээний газруудад байна.


Хүснэгт 3.1.

Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлгээр, байршлаар

Насны бүлэг	Бүгд	Үүнээс: Судалгаанд хамрагдагчид, байршлаар					
		Гудамж, талбай	Караоке, баар, цэнгээний газар				Саун, массажны газар
			Бүртгэлтэй		Бүртгэлгүй		
			30 хүртэл суудалтай	30 ба түүнээс дээш суудалтай	30 хүртэл суудалтай	30 ба түүнээс дээш суудалтай	
Бүгд	4 640	633	465	2 453	92	470	527
18-20	586	55	39	438	-	16	38
21-24	1 452	132	116	786	41	140	237
25-29	1 017	118	155	521	19	91	113
30-34	750	112	97	324	17	98	102
35-39	572	92	39	340	15	59	27
40-44	189	101	-	30	-	48	10
45-49	55	23	-	14	-	18	-
50 ба түүнээс дээш	19	-	19	-	-	-	-

Зураг 3.1.

Биеэ үнэлэгчдийн байршил, хувиар



Судалгаа Улаанбаатар хотын Багахангай дүүргээс бусад найман дүүрэгт явагдсан ба нийт биеэ үнэлэгчдийг байршлаар нь авч үзэхэд 31.5 хувь нь Баянгол, 26.1 хувь нь Сүхбаатар, 17.0 хувь нь Баянзүрх, 13.9 хувь нь Чингэлтэй, 7.2 хувь нь Сонгинохайрхан, 3.9 хувь нь Хан-Уул, 0.4 хувь нь Налайх дүүргүүдэд байгааг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 3.2.

Биеэ үнэлэгчид насны бүлгээр, дүүргээр, хувиар

Насны бүлэг	Бүгд		Үүнээс: дүүргээр						
	Тоо	Хувь	Хан-Уул	Баянзүрх	Налайх	Баянгол	Сүхбаатар	Чингэлтэй	Сонгинохайрхан
Бүгд	4 640	100.0	3.9	17.0	0.4	31.5	26.1	13.9	7.2
18-20	586	100.0	4.7	20.6	0.3	48.0	20.8	3.2	2.4
21-24	1 452	100.0	1.8	29.8	0.1	28.7	21.1	13.8	4.7
25-29	1 017	100.0	3.4	11.0	0.2	33.2	27.0	19.0	6.2
30-34	750	100.0	4.6	4.7	0.4	36.0	26.5	12.9	14.9
35-39	572	100.0	3.7	4.2	0.7	26.6	42.8	15.2	6.8
40-44	189	100.0	15.3	15.9	3.2	2.1	28.6	15.3	19.6
45-49	55	100.0	14.5	25.5	1.8	-	21.8	36.4	-
50 ба түүнээс дээш	19	100.0	-	100.0	-	-	-	-	-

Нийт биеэ үнэлэгчдийг насны бүлгээр нь авч үзвэл 18-39 насны хүмүүс илүү биеэ үнэлж байгаа ба дийлэнх буюу 31.3 хувь нь 21-24 насныхан байна. Харин хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн 52.5 хувийг 18-20 насныхан, эмэгтэйчүүдийн 31.5 хувийг 21-24 насныхан эзэлж байна.

Хүснэгт 3.3.


Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлгээр

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Хувь %	Тоо	Хувь %	Тоо	Хувь %
Бүгд	4 640	100.0	40	100.0	4 600	100.0
18-20	586	12.6	21	52.5	565	12.3
21-24	1 452	31.3	5	12.5	1 447	31.5
25-29	1 017	21.9	-	-	1 017	22.1
30-34	750	16.2	2	5.0	748	16.3
35-39	572	12.3	-	-	572	12.4
40-44	189	4.1	8	20.0	181	3.9
45-49	55	1.2	4	10.0	51	1.1
50 ба түүнээс дээш	19	0.4	-	-	19	0.4

Биеэ үнэлэгчийг насны бүтцийнх нь хувьд таллан хуваах буюу насны голчийг үзэхэд 34 байгаа бөгөөд хамгийн залуу нь 18 настай, хамгийн ахмад нь 53 настай хүн байв.

Зураг 3.2.

Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлэг, хүйсээр



3.2 Биеэ үнэлэгчдийн ерөнхий шинж байдал

Биеэ үнэлэгчдийн боловсролын түвшний байдлыг үзвэл таван хүн тутмын гурав нь бүрэн дунд боловсролтой, нэг нь дээд/бакалаврын боловсролтой байна. Харин биеэ үнэлэгчдийн дунд боловсролгүй, бага боловсролтой хүний эзлэх хувь ердөө 2.6 хувь байгаа сонирхолтой дүн гарсан.


Хүснэгт 3.4.

Биеэ үнэлэгчдийн боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	Бүгд		Үүнээс: хүйсээр	
	Тоо	Хувь	Эрэгтэй	Эмэгтэй
Магистр	28	0.6	-	0.6
Дээд/ бакалавр	789	17.0	-	17.2
Дипломын дээд/ тусгай мэргэжлийн дунд	301	6.5	25.0	6.3
Мэргэжлийн анхан шатны	145	3.1	-	3.1
Бүрэн дунд	2 960	63.8	65.0	63.8
Суурь	298	6.4	10.0	6.4
Бага	93	2.0	-	2.0
Боловсролгүй	26	0.6	-	0.6
Дүн	Хувь	100.0	100.0	100.0
	Тоо	4 640	-	4 600

Зураг 3.3.


Биеэ үнэлэгчдийн боловсролын түвшингийн бүтэц, дүнд эзлэх хувиар



Биеэ үнэлэгчдийн 17.0 хувь нь их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд сурч байна /зураг 3.4/. Сургуульд сурдаггүй хүний 52.4 хувь нь өмнө нь ямар нэгэн шатны сургуульд суралцаж байгаад гарсан, сургууль завсардсан хүн байсан бөгөөд 60.0 хувь нь ерөнхий боловсролын сургуулиас, 39.6 хувь нь их, дээд сургуульд суралцаж байгаад сургуулиас гарсан байна. Харин 1.4 хувь нь аль нэг шатаны сургуульд сурч байснаа мэдэхгүй гэж хариулсан байна.


Зураг 3.4.

Суралцагчид, сургуулийн төрөл, хувиар



Зураг 3.5.

Сургуулиас завсардсан биеэ үнэлэгчид, шалтгаан, хувиар



Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс гарсан болон сургууль завсардсан гол шалтгааныг тодруулахад сургууль завсардсан нийт хүний 52.3 хувь санхүүгийн бэрхшээлээс, 12.0 хувь нь сонирхолгүй, 8.3 хувь нь ажил хийх гээд, 1.4 хувь нь бичиг баримтын бүртгэл байхгүйгээс, 1.3 хувь нь эцэг, эх хориглосон, 0.9 хувь нь өвчний улмаас сургуулиас гарчээ.

Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан хүний 41.7 хувь нь ахлах ангид, 41.0 хувь нь дунд ангид, 17.3 хувь нь бага ангид байхдаа сургуулиасаа гарсан байна. Их, дээд сургуульд суралцаж байгаад сургуулиа орхисон хүний 32.3 хувь нь 1-р дамжаа, 55.2 хувь нь 2-р дамжаа, 11.8 хувь нь 3-р дамжаа, 0.7 хувь нь 4-р дамжаанаас сургуулиасаа гарсан байна.


Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс гарсан, сургууль завсардсан болон сургуульд огт суралцаж байгаагүй хүний 23.9 хувь нь ямар нэгэн албан бус сургалтанд хамрагдаж байсан бол 76.1 хувь нь хамрагдаж байгаагүй ажээ.

Биеэ үнэлэгчдийн хоёр хүн тутмын нэг нь ямар нэгэн шашин шүтдэг ба шашны төрлөөр авч үзвэл 60.4 хувь нь будда, 20.8 хувь нь христ, 18.8 хувь нь бөөгийн шашинтай хүмүүс байна.

Судалгааны дүнгээр биеэ үнэлэгчдийн 40.7 хувь нь одоогийн оршин сууж буй газартаа 5-аас доош жил, 59.3 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай амьдарч байна. Шилжих хөдөлгөөн хийсэн биеэ үнэлэгчдийн 35.1 хувь нь сүүлийн 1 жилд, 64.9 хувь нь сүүлийн 4 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оржээ.


Зураг 3.6.

Биеэ үнэлэгчдийн одоогийн оршин сууж буй газраа бүртгүүлээгүй байгаа шалтгаан, хувиар



Зураг 3.7.


Шилжин ирсэн биеэ үнэлэгчид, хамт ирсэн хүнээр, хувиар



Шилжин ирсэн биеэ үнэлэгчдийн 72.4 хувь нь одоогийн оршин сууж буй орон нутгийн засаг захиргаандаа бүртгүүлээгүй байгаа ба бүртгүүлээгүй гол шалтгаануудыг Зураг 3.6-д харууллаа.

Зураг 3.8.

Шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн шилжих болсон шалтгаан, хувиар



Шилжин ирсэн биеэ үнэлэгчдийн шилжин ирэх болсон шалтгааныг Зураг 3.8 –аас харахад арван хүн тутмын гурав нь суралцахаар болон ажил хийхээр шилжин иржээ. Харин таван хүн тутмын нэг нь эцэг, эх, гэр бүлээ дагаад шилжин ирсэн байна.

Нийт биеэ үнэлэгчдийн 57.3 хувь нь огт гэр бүл болоогүй, 9.4 хувь нь гэрлэсэн, 3.7 хувь нь бэлэвсэн байна. Уг харьцаа мөн хүйсээр хадгалагдаж байгаа нь дараах хүснэгтээс ажиглагдаж байна.

Хүснэгт 3.5.

Биеэ үнэлэгчдийн гэрлэлтийн байдал, хүйсээр, дүнд эзлэх хувиар

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Огт гэр бүл болоогүй	57.3	65.0	57.2
Гэрлэсэн	9.4	20.0	9.3
Хамт амьдардаг	4.9	-	5
Тусдаа амьдардаг	6.1	-	6.2
Салсан	18.6	10.0	18.6
Бэлбэсэн	3.7	5.0	3.7
Дүн	Хувь	100.0	100.0
	Тоо	4 640	40
Бүгдээс: -Гэрлэсэн хүний тоо		434	426


Гэр бүлийн байдал, ам бүлийн тоо, гэр бүлийнхэнтэйгээ ямар харилцаа холбоотой байдаг, гэрийн хүмүүжлээс шалтгаалан тухайн хүний биеэ авч явах байдал, цаашлаад биеэ үнэлэх шалтгаан болж болох талтай юм. Иймд судалгаанд оролцогчдын гэр бүлийн харьцаа, харилцан ойлголцол, гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдардаг эсэхийг тогтоохыг зорьсон.

Судалгааны үр дүнгээр биеэ үнэлэгч хоёр хүний нэг нь гэр бүлийнхэнтэйгээ хааяа ойлголцдог, таван хүн тутмын хоёр нь маш сайн ойлголцдог гэсэн бол харин ойлголцож чаддаггүй гэсэн хүн нийт биеэ үнэлэгчдийн 8 хувийг эзэлж байна /Зураг 3.9/.

Насны бүлгээр авч үзэхэд 18-34 насныхны 55.7 хувь нь хааяа ойлголцдог, 37.1 хувь нь маш сайн ойлголцдог, 7.2 хувь нь ойлголцож чаддаггүй, 40-44 насныхны 76.2 хувь нь маш сайн ойлголцдог, 17.5 хувь нь ойлголцож чаддаггүй, 6.3 хувь нь хааяа ойлголцдог, 45-49 насныхны 69.1 хувь нь маш сайн ойлголцдог, 25.5 хувь нь хааяа ойлголцдог, 5.4 хувь нь ойлголцож чаддаггүй бол харин 50 ба түүнээс дээш насныхан гэр бүлийнхэнтэйгээ маш сайн ойлголцдог байна.


Зураг 3.9.

Гэр бүлийнхэнтэйгээ хэр ойлголцдог эсэх, хувиар



Зураг 3.10.

Биеэ үнэлэгчдийн өрхийн ам бүлийн тоо, хувиар




Биеэ үнэлэгчдийн өрхийн ам бүлийн байдлыг авч үзэхэд таван хүн тутмын нэг нь 4-6 ам бүлтэй байна. Дээрх 3.10-р зургаас үзэхэд биеэ үнэлэгчдийн өрхийн дундаж ам бүлийн тоо 5 байна.

Судалгааны дүнгээр нийт биеэ үнэлэгчдийн 72.6 хувь нь гэр бүлийн зүгээс ямар нэгэн дарамттай байдаг гэж хариулжээ. Учирдаг дарамт, шахалтуудыг дараах 3.11-р зургаас харахад хоёр хүн тутмын нэг нь сэтгэл зүйн дарамт, заналхийлэлтэй байдаг, арван хүн тутмын нэг нь гэрээсээ хөөгддөг, мөнгө олж ир гэж хөөдөг, бие махбодийн дарамттай байдаг дүн харагдаж байна.


Зураг 3.11.

Гэр бүлийнхнээс нь учруулдаг дарамт, шахалтууд, хувиар



Зураг 3.12.


Гэр бүлийнхнээсээ тусдаа амьдардаг биеэ үнэлэгчид, хамт амьдардаг хүн, хувиар



Биеэ үнэлэгчдийн 42.5 хувь нь гэр бүлийнхэнтэйгээ цуг амьдардаггүй байна. Гэр бүлээсээ гадуур амьдарч байгаа хүмүүсийн хамт амьдрагчдынх нь бүтцээр авч үзэхэд арван хүн тутмын гурав нь найз залуу, охинтойгоо цуг, таван хүн тутмын нэг нь ганцаараа болон найзуудтайгаа амьдардаг байна /зураг3.12/.


Зураг 3.13.

Хүүхэдтэй биеэ үнэлэгчид, хүүхдийн тоогоор, хувиар



Зураг 3.14.

Одоо амьдарч буй орчин, хувиар



Нийт биеэ үнэлэгчдийн 52.7 хувь нь хүүхэдгүй, 47.3 хувь нь хүүхэдтэй ба тэднийг хүүхдийнх нь тоогоор авч үзэхэд 76.2 хувь нь нэгээс хоёр хүүхэдтэй, 23.8 хувь нь гурав

ба түүнээс дээш хүүхэдтэй байна. Мөн хүүхэдтэй биеэ үнэлэгч хоёр хүний нэг нь 5 хүртлэх бага насны хүүхэдтэй ажээ.

Нийт биеэ үнэлэгчдийн 38.6 хувь нь өөрийн гэсэн амьдрах сууцтай байхад 61.4 хувь нь түрээсийн, дотуур байрууд гэх мэт өөрийн гэсэн амьдрах сууцгүй байна.

Судалгааны дүнгээр нийт биеэ үнэлэгчдийн бараг гурван хүний нэг нь биеэ үнэлэхээсээ гадна ямар нэгэн цалин хөлстэй ажил эрхэлж байна. Ажил эрхэлж буй биеэ үнэлэгчдийг насны бүлгээр нь авч үзвэл 21-24 насныхны дунд ажил эрхлэлт өндөр харагдаж байна.

Хүснэгт 3.6.

Биеэ үнэлэгчдийн ажил эрхлэлт, хүйсээр, дүнд эзлэх хувиар


Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		
	Ажилладаг	Ажилладаггүй	Ажилладаг	Ажилладаггүй	Ажилладаг	Ажилладаггүй	
18-20	8.4	14.4	73.1	14.3	7.1	14.4	
21-24	39.9	27.8	19.2	-	40.3	27.9	
25-29	21.1	22.2	-	-	21.5	22.4	
30-34	14.8	16.7	7.7	-	14.9	16.8	
35-39	12.9	12.1	-	-	13.2	12.1	
40-44	1.7	5.0	-	57.1	1.7	4.8	
45-49	1.2	1.2	-	28.6	1.3	1	
50 ба түүнээс дээш	-	0.6	-	-	-	0.6	
Дүн	Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
	Тоо	1 347	3 293	26	14	1 321	3 279

Одоо болон өмнө нь ажил эрхэлж байсан нийт хүнийг анх ажил хийж эхэлсэн насны бүлгээр нь авч үзвэл хоёр хүн тутмын нэг нь 18-20 насандаа, таван хүн тутмын нэг нь 21-24 хүртлэх насандаа анх ажил эрхэлж эхэлсэн байна.

Өмнө нь ажил эрхэлж байсан нийт хүний 29.2 хувь нь цалин бага учраас, 26.6 хувь нь бусад шалтгаанаар, 9.7 хувь нь их дээд сургууль коллежид суралцах зорилгоор, 8.9 хувь нь ажиллах нөхцөл муу, 7.6 хувь нь өөр ажилд орохоор, 7.2 хувь нь хамт ажиллагчид дарамталдаг байсан, 6.7 хувь нь ажлаас халагдсан, 4.1 хувь нь ажил олгогчийн зүгээс дарамталдаг гэсэн шалтгаанаар ажлаас гарчээ.


Зураг 3.15.

Анх ажил хийж эхэлсэн насны бүлэг, хувиар



Зураг 3.16.

Ажлаас гарсан шалтгаан, хувиар



3.3 Биеэ үнэлэлт


Энэ хэсэгт биеэ үнэлэгчдийн хэдий хугацаанд биеэ үнэлж байгаа, энэ зам руу ороход нөлөөлсөн хүчин зүйлс, тэдэнд тохиолдож буй бэрхшээл, тэдний үйлчлүүлэгчид болон зуучлагчдын шинж байдлын талаарх судалгааны гол дүнг танилцуулах болно.

3.3.1. Биеэ үнэлж буй хугацаа

Биеэ үнэлэгчдийн хувьд биеэ үнэлж буй хугацааг авч үзвэл дунджаар 4 жил биеэ үнэлж байна гэсэн дүн гарч байна.

Зураг 3.17.

Биеэ үнэлж буй хугацаа, хувиар



Биеэ үнэлэгчдийн 49.6 хувь нь 1-3 жил биеэ үнэлж байгаа бөгөөд хүйсээр авч үзвэл дээд тал нь эмэгтэйчүүд 26 жил, эрэгтэйчүүд 12 жил биеэ үнэлжээ.

Биеэ үнэлэгчдийн биеэ үнэлж буй хугацааг байршлаар авч үзэхэд гудамж талбайд зогсогчдын гурван хүн тутмын нэг орчим нь 15 ба түүнээс дээш жилийн хугацаатай биеэ үнэлж буй биеэ үнэлэгчид байгаа бөгөөд нийт биеэ үнэлэгч хоёр хүн тутмын нэг нь томоохон хэмжээний караоке, баар, цэнгээний газраар байршиж байгаа нь мөн биеэ үнэлж буй хугацаагаар бүлэглэсэн бүлэг тус бүр дээр хадгалагдаж байна.


Хүснэгт 3.7.

Биеэ үнэлэгчдийн биеэ үнэлж буй хугацаа, байршлаар, дүнд эзлэх хувиар

Хугацаа	Бүгд		Үүнээс: Судалгаанд хариулагчийн байршил					Саун, массажны газар
	Тоо	Хувь	Гудамж, талбай	караоке, баар, цэнгээний газар				
				бүртгэлтэй		бүртгэлгүй		
				30 хүртэл суудалтай	30 ба түүнээс дээш суудалтай	30 хүртэл суудалтай	30 ба түүнээс дээш суудалтай	
Бүгд	4 640	100.0	631	465	2 459	91	469	525
Эхний жил	97	100.0	22.7	0.0	53.6	12.4	7.2	4.1
1-3 жил	2 303	100.0	12.7	13.5	46.9	2.6	9.8	14.5
4-6 жил	1 162	100.0	12.0	8.3	60.3	0.9	10.2	8.3
7-9 жил	673	100.0	11.4	5.8	59.7	0.0	10.8	12.3
10-14 жил	285	100.0	23.2	0.0	59.6	3.2	11.2	2.8
15 ба түүнээс дээш жил	120	100.0	28.4	15.8	45.8	0.0	10.0	0.0

Зураг 3.18.

Биеэ анх үнэлж эхэлсэн насны бүлэг, хувиар



Биеэ үнэлж эхэлсэн анхны наснаас харахад хамгийн бага нь 14, хамгийн ахмад нь 44 настайдаа, дунджаар 23 настайдаа биеэ үнэлж эхэлсэн байна. Ерөнхийдөө судалгаагаар илэрсэн биеэ үнэлэгчдийн 14.4 хувь нь 18 насанд хүрээгүй байх үедээ биеэ үнэлж эхэлсэн байна.

Хүснэгт 3.8.

Биеэ үнэлэгчдийн тоо, анх биеэ үнэлж эхэлсэн насны бүлгээр, байршлаар, дүнд эзлэх хувиар

Анх биеэ үнэлж эхэлсэн насаар	Бүгд	Үүнээс: Судалгаанд хариулагчийн байршил					
		Гудамж, талбай	караоке, баар, цэнгээний газар				Саун, массажны газар
			бүртгэлтэй		бүртгэлгүй		
			30 хүртэл суудалтай	30 ба түүнээс дээш суудалтай	30 хүртэл суудалтай	30 ба түүнээс дээш суудалтай	
Бүгд	100.0	14.2	8.7	57.1	-	10.1	9.9
18 хүртэл	100.0	3.5	5.3	76.0	1.5	2.5	11.2
18-20	100.0	10.0	11.7	52.5	2.7	10.9	12.2
21-24	100.0	19.6	10.4	46.3	1.6	8.3	13.8
25-29	100.0	26.0	10.7	37.3	3.0	15.9	7.1
30-34	100.0	53.2	17.8	-	3.7	17.8	7.5
35-39	100.0	27.1	-	14.6	-	58.3	-
40-44	100.0	13.6	10.0	53.0	2.0	10.1	11.3


3.3.2. Биеэ үнэлэх болсон шалтгаан

Биеэ үнэлэгчдийн биеэ үнэлэх болсон анхны болон одоогийн шалтгаанд мөнгө олох зорилго голлож байгаа буюу хоёр хүн тутмын нэг нь ийм шалтгаантай байна. Мөн үүний дараагаар арван хүн тутмын нэг нь зөвхөн сургалтын төлбөрөө олох болон гэр бүлээ тэжээх шалтгаанаар биеэ үнэлж байна.

Биеэ үнэлэгчдийн 80.9 хувийг нь гэр бүлийнхэн нь одоогоор биеэ үнэлж байгааг нь мэддэггүй байна.


Зураг 3.19.

Биеэ үнэлж эхлэхэд анх уруу татсан хүн, хувиар



Зураг 3.20.

Анх хүчиндсэн хүн, хувиар



Биеэ үнэлэгчдийг анх уруу татсан хүнийг Зураг 3.19-өөс харвал таван хүн тутмын хоёр нь өөрийн сонирхлоороо биеэ үнэлж эхэлсэн байхад, хоёр хүн тутмын нэгийг нь найз болон найз залуу, охин, таньдаг хүн нь анх уруу татсан байна.


Нийт биеэ үнэлэгчдийн 10.5 хувь нь биеэ үнэлэхээсээ өмнө хүчиндүүлж байсан бөгөөд 86.5 хувь нь нэг удаа, 8.8 хувь нь хоёр удаа, 1.0 хувь нь гурван удаа, 3.7 хувь нь дөрөв ба түүнээс дээш удаа хүчиндүүлж байжээ. Мөн тэдгээрийг хүчиндсэн таван хүн тутмын хоёр нь таньдаг хүн нь байсан байна /Зураг 3.20/.

3.3.3. Биеэ үнэлж буй орчин, нөхцөл

Биеэ үнэлэгчдийн анхны болон одоогийн үйлчлүүлэгчээ олж байгаа газруудыг хооронд нь харьцуулж үзэхэд үйлчлүүлэгчийн дуудлагаар очиж үйлчилдэг биеэ үнэлэгчдийн хувь нэмэгдсэн бөгөөд арван хүн тутмын гурав нь дугаараа зарлан утсаар ярьж, таван хүний нэг нь лавлах утсаар холбогдон очдог, бараг арван хүн тутмын нэг нь буудлын жижүүр, зуучлагчийн дуудлага, харуул хамгаалалтын ажилтан, найз нөхөд болон телевизийн чатаар дамжуулан үйлчлүүлэгчийн дуудлагаар очиж үйлчилдэг байна.


Зураг 3.21.

Анх үйлчлүүлэгчээ олж авч байсан газар, хувиар



Зураг 3.22.

Одоо үйлчлүүлэгчээ олж авч байгаа газар, хувиар



Хүснэгт 3.9.

Биеэ үнэлэгчдийн анхны болон одоогийн үйлчлүүлэгчдээ олж авч буй байршил, хувиар


Байршил	Биеэ үнэлэгчдийн тоо		Бүтэц		Зөрүү	
	Анхны	Одоогийн	Анхны	Одоогийн		
Гудамжинд зогсож	1 810	1 005	39.0	21.7	-17.3	
Саун/массажны газарт	564	557	12.2	12.0	-0.2	
Буудалд	250	128	5.4	2.8	-2.6	
Үйлчлүүлэгчийн дуудлагаар	96	147	2.1	3.2	1.1	
Зуучлагчаар дамжуулж	176	141	3.8	3.0	-0.8	
Шөнийн клуб/баар цэнгээний газарт	1 509	2 350	32.5	50.6	18.1	
Жуулчны баазад	34	13	0.7	0.3	-0.4	
Барилгын талбай дээр очиж	48	5	1.0	0.1	-0.9	
Бусад	153	294	3.3	6.3	3.0	
Дүн	Хувь	-	-	100.0	100.0	-
	Тоо	4 640	4 640	-	-	-

Биеэ үнэлэгчдийн 38.8 хувь нь сүүлийн нэг жилд биеэ үнэлдэг газраа өөрчилсөн байгаа бөгөөд өөрчилсөн шалтгааныг тодруулахад 38.2 хувь нь илүү мөнгө олох, аюулгүй, боломжийн орчинд ажиллах, 24.4 хувь нь зүгээр л, 8.7 хувь нь цагдаагийн дарамт, 1.7 хувь нь бусад, 0.8 хувь нь зуучлагчтайгаа таараагүй шалтгаанаар биеэ үнэлдэг газраа өөрчилжээ.

Сүүлийн үед биеэ үнэлэгчид гадаадад гарч биеэ үнэлэх явдал нилээдгүй бий болоод байгаа бөгөөд судалгааны дүнгээр биеэ үнэлэгчдийн 4.9 хувь нь гадаадад гарч биеэ үнэлж байсан ба тэдний 25.8 хувь нь гадаад руу гарахдаа биеэ үнэлэхээ мэдээгүй байсан байна.


Зураг 3.23.

Биеэ үнэлэгчдийн биеэ үнэлж байсан улс, орнууд, хувиар



Зураг 3.24.

Биеэ үнэлэгчдийг гадаадад гарахад нь тусалсан хүн, хувиар



3.3.4. Биеэ үнэлж олж буй орлого, түүний зарцуулалт

Биеэ үнэлэгчдийн 99.4 хувь нь хөлсөө үйлчлүүлэгчдээс бэлэн мөнгөөр авдаг байхад үлдсэн 0.6 хувь нь мөнгөн бус хэлбэрээр авдаг байна. Мөн тэдний 92.2 хувь нь хөлсөө шууд авдаг байхад 5.4 хувь нь зуучлуулагчаар дамжуулж, 2.6 хувь нь шууд болон зуучлагчаар дамжуулж авдаг байна.

Биеэ үнэлэгчдийн сарын орлогыг авч үзэхэд 61.2 хувь нь 200.0-500.0 мянган төгрөгийн орлоготой байдаг байна.

Хүснэгт 3.10.


Биеэ үнэлэгчдийн сарын орлого, хүйсээр, хувиар

Орлого	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
50000 хүртэл	0.9	-	0.9
50000-99999	1.5	-	1.6
100000-199999	9.6	10.0	9.6
200000-299999	15.9	12.5	16.0
300000-399999	27.7	25.0	27.7
400000-499999	17.7	52.5	17.3
500000-599999	7.2	-	7.2
600000-699999	10.4	-	10.5
700000-799999	3.0	-	3.0
800000 ба түүнээс дээш	6.1	-	6.2
Дүн			
Хувь	100.0	100.0	100.0
Тоо	4 640	40	4 600

Биеэ үнэлэгчдийн 21.9 хувь нь олсон орлогоо өөрт хэрэгтэй эд зүйлсээ худалдан авахад, 18.8 хувь нь хоол хүнсээ худалдан авахад хэрэглэдэг байна. Орлогын зарцуулалтыг дараах зургаар харуулав.

Зураг 3.25

Биеэ үнэлэгчдийн орлогын зарцуулалт, хувиар



3.3.5. Үйлчлүүлэгчид болон зуучлагчдын шинж байдал

Энэ хэсэгт биеэ үнэлэгчдийг зуучлах ажил эрхэлдэг зуучлагч болон тэдгээрээр үйлчлүүлдэг үйлчлүүлэгчдийн талаар дэлгэрэнгүй авч үзье.

Үйлчлүүлэгчид

Судалгааны дүнгээр биеэ үнэлэгчид өдөрт дунджаар 3 хүнд үйлчилдэг байна. Үйлчлүүлэгчийн дундаж нас 34 байгаа ба хамгийн залуу нь 15 настай, хамгийн ахмад нь 80 настай хүн байна.

Биеэ үнэлэгчдийн 48.1 хувь нь гадаадын хүмүүст үйлчилж байсан ба тэдэнд үйлчилсэн биеэ үнэлэгчийн насыг харвал 36.0 хувь нь 21-24 насныхан, 26.7 хувь нь 25-29 насныхан, 22.5 хувь нь 30-34 насныхан, 6.0 хувь нь 35-34 насныхан, 5.9 хувь нь 18-20

насныхан, 1.7 хувь нь 40-44 насныхан, 1.2 хувь нь 45-49 насныхан байна. Гадаадын үйлчлүүлэгчдийн гурван хүний нэг нь БНХАУ-ын иргэд байна /зураг 3.27/.

Нийт биеэ үнэлэгчдийн 50.2 хувь нь үйлчлүүлэгчдээс бэлгийн харьцаанд орохоос өөр санал хүлээн авч байжээ. Хүлээж авсан саналын 55.1 хувь нь болзоонд урих, 14.8 хувь нь гадаадад ажиллах, 11.9 хувь нь монголд өөр ажил эрхлэх, 7.7 хувь нь гэрлэх, 10.5 хувь нь бусад саналууд эзэлж байна.

Биеэ үнэлэгчдийн 51.2 хувь нь бусдаас охид, эмэгтэйчүүдийг олж өгөөч гэсэн санал сонсож байсан байна /Зураг 3.26/.


Зураг 3.26.

Охид эмэгтэйчүүдийг олж өгөөч гэсэн, санал тавьж байсан хүн, хувиар



Зураг 3.27.

Үйлчлүүлж байсан гадаадын хүн, хувиар




Зуучлагчид

Судалгааны дүнгээр биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн 16.5 хувь нь зуучлагчаар дамжуулж үйлчлэгч олж, биеэ үнэлдэг байна. Зуучлагчтай биеэ үнэлэгчид нь дандаа эмэгтэйчүүд байсан.

Зуучлагчийн хувьд 51.9 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба нийт зуучлагчдын хоёр хүний нэг нь 25-34 насныхан байна.


Зураг 3.28.

Зуучлагчтай биеэ үнэлэгчдийн насны бүлэг, хувиар



Зураг 3.29.


Зуучлагчид насны бүлгээр, хувиар



Зуучлагчтай биеэ үнэлэгчдийн 59.8 хувь нь анх зуучлуулж байхдаа зуучлагчаа огт таньдаггүй, 26.4 хувь нь бага зэрэг таньдаг, 13.8 хувь нь сайн таньдаг байжээ. Биеэ үнэлэгчид зуучлагчтайгаа хэрхэн танилцсан талаар авч үзвэл 62.3 хувь нь найзаараа дамжуулж, 28.3 хувь нь өөрөө олж танилцсан, 5.0 хувь нь үерхдэг найз залуу, охин нь байсан, 3.2 хувь нь бусад, 1.2 хувь нь өмнө нь хуурай ах, эгч, дүү байцгаасан гэсэн хариулт өгчээ. Биеэ үнэлэгч хүсвэл дуртай үедээ зуучлагчаасаа явах боломжийг асуухад 50.9 хувь нь боломжтой, 19.8 хувь нь хариулж мэдэхгүй байна, 16.3 тухайн үеийн байдлаасаа болно, 13.0 хувь нь боломжгүй гэсэн хариулт өгчээ. Зуучлагчаас явах боломжгүй хүмүүсийн шалтгааныг тодруулахад 77.8 хувь нь дарамталдаг, доромжилж зоддог, чөлөөтэй байлгадаггүй, 19.2 хувь нь оюутан болохоор мөнгөний хэрэгцээ их байдаг, 3.0 хувь нь сайн мэдэхгүй байна гэсэн байна.

Зураг 3.30.

Биеэ үнэлэгчдэд зуучлагчдаас үзүүлж буй туслалцаа, хувиар




3.3.6. Биеэ үнэлэгчдэд тохиолдож буй хүндрэл, бэрхшээл

Биеэ үнэлэгчид нь үйлчлүүлэгч болон зуучлагчтайгаа зөрчилдөж, тэдний дарамт шахалтад орох явдал цөөнгүй гардаг байна. Иймд энэ судалгаагаар биеэ үнэлэгчдийн биеэ үнэлэх үйл явцаас гадна, тэдэнд тулгардаг хүндрэл, бэрхшээлийг судалж үзлээ.

Биеэ үнэлэгчдийн 49.1 хувь нь биеэ үнэлэх явцдаа ямар нэгэн гэмтэл авч байсан бөгөөд 87.6 хувийг нь үйлчлүүлэгч учруулдаг байна.

Нийт биеэ үнэлэгчдийн 63.4 хувь нь үйлчлүүлэгчдийн зүгээс дарамт шахалт хааяа учруулдаг гэсэн бол 10.6 хувь нь байнга, харин 26.0 хувь нь дарамт шахалт, хүндрэл учирдаггүй гэж хариулжээ.

Зураг 3.31.
Үйлчлүүлэгчдийн зүгээс үзүүлдэг дарамт, шахалт, хувиар



Зураг 3.32.
Зуучлагчдын зүгээс үзүүлдэг, дарамт, шахалт, хувиар



Биеэ үнэлэгчдэд ямар нэгэн аюул учирсан тохиолдолд хамгийн түрүүнд цагдаагийн байгууллагад /47.3 хувь нь/, найз нөхдөдөө /19.7 хувь нь/, хамтран ажиллагчиддаа /5.5 хувь нь/, зуучлагчиддаа /4.5 хувь нь/, эцэг, эх, ах, эгч, дүү нартаа /4.2 хувь нь/, нөхөр, эхнэртээ /3.0 хувь нь/, төрийн бус байгууллагуудад /1.9 хувь нь/ ханддаг бол зарим нь хэнд ч ханддаггүй /13.9 хувь нь/ байна.

Биеэ үнэлсэний улмаас хуулийн арга хэмжээ авахуулж байсан биеэ үнэлэгчид 49.2 хувийг эзэлж байгаа ба авахуулж байсан төрлөөр нь авч үзвэл торгуулсан хүн 52.0 хувь, баривчлагдсан 44.9 хувь, эрүүгийн хэрэгт татагдсан 3.0 хувь, сануулга авч байсан хүн 1.0 хувийг эзэлж байна.

3.4 Эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ХДХВ өвчний талаарх мэдлэг

Биеэ үнэлэгчдийн анхны бэлгийн харьцаанд орсон дундаж нас 19 байгаа бөгөөд хамгийн багадаа 13 настайдаа анх бэлгийн харьцаанд орж байсан байна. Тэдний 50.9 хувь нь 16-18 насандаа, 42.8 хувь нь 19-21 насандаа, 3.6 хувь нь 13-15 насандаа, 2.7 хувь нь 22 ба түүнээс дээш насандаа анх бэлгийн харьцаанд оржээ.

Анх бэлгийн харьцаанд орохдоо 57.5 хувь нь найз залуу, охинтойгоо, 21.8 хувь нь таньдаг хүнтэйгээ, 16.8 хувь нь нөхөр, эхнэртэйгээ, 3.9 хувь нь таньдаггүй хүнтэй орсон байлаа.

Анх бэлгийн харьцаанд орж байсан нөхцлийг харвал биеэ үнэлэгчдийн 40.0 хувь нь өөрийн хүслээрээ, 30.7 хувь нь харилцан тохиролцож, 23.1 хувь нь санамсаргүй тохиолдлоор, 3.3 хувь нь хүчиндүүлж, 2.8 хувь нь хууран мэхлэгдэж, 0.1 хувь нь биеэ үнэлж анхныхаа бэлгийн харьцаанд оржээ.


Хүснэгт 3.11.

Бэлгийн харьцаанд анх ямар нөхцөлд, хэнтэй орж байсан байдал, хувиар

Анх бэлгийн харьцаанд орж байсан хүн	Нийт	Өөрийн хүслээр	Харилцан тохиролцож	Санамсаргүй тохиолдлоор	Хүчиндүүлж	Хууран мэхлэгдэж	Биеэ үнэлж
Нөхөртэйгээ/эхнэртэйгээ	776	32.0	9.9	1.6	1.9	15.4	25.0
Найз залуу/охин	2 668	63.1	69.2	43.9	6.5	23.8	-
Таньдаг хүн	1 014	4.9	20.9	50.0	24.1	37.7	75.0
Таньдаггүй хүн	182	-	-	4.5	67.5	23.1	-
Дүн	Хувь	-	100.0	100.0	100.0	100.0	100.0
	Тоо	4 640	1 856	1 424	1 072	154	4

Зураг 3.33.

Биеэ үнэлэгчид, хэдэн удаа үр хөндүүлж байснаар, хувиар



Биеэ үнэлэгчдийн 52.3 хувь нь үр хөндүүлж байсан бөгөөд насны бүлгээр авч үзвэл 25-29 насны биеэ үнэлэгч эмэгтэйчүүд 28.3 хувь, 30-34 насныхны 23.0 хувь, 21-24 насныхан 21.4 хувь, 35-39 насныхан 12.1 хувь, 18-20 насныхан 8.6 хувь, 40-44 насныхан 4.9 хувь, 45-49 насныхан 1.7 хувь байна. Үүнээс үзэхэд 21-34 насныхны дунд үр хөндөлт өндөр байгаа нь харагдаж байна.

Биеэ үнэлэгч таван хүн тутмын гурав нь ихэнхдээ үйлчлүүлэгчтэйгээ бэлгийн харьцаанд ордог бол, бараг арван хүний нэг нь найз залуу, охин болон таньдаг найзтайгаа бэлгийн харьцаанд ордог байна.

Хүснэгт 3.12.

Биеэ үнэлэгчид, бэлгийн харьцаанд голлон ордог хүнээр, насны бүлэг, хувиар

Насны бүлэг	Бүгд		Найз залуу/охин	Нөхөртэйгээ/эхнэртэйгээ	Таньдаг найзтайгаа	Үйлчлүүлэгчтэй	Зуучлагч -тай	Бусад
	Тоо	Хувь						
18-20	586	100.0	7.2	3.2	12.8	76.1	0.7	-
21-24	1 452	100.0	18.0	1.2	17.0	63.0	-	0.8
25-29	1 017	100.0	24.5	2.3	16.0	56.7	-	0.5
30-34	750	100.0	6.5	6.7	12.7	71.9	2.1	0.1
35-39	572	100.0	12.6	19.9	3.3	64.2	-	-
40-44	189	100.0	-	14.8	-	84.7	-	0.5
45-49	55	100.0	3.7	12.7	7.3	72.7	-	3.6
50 ба түүнээс дээш	19	100.0	-	-	-	100.0	-	-
Нийт	4 640	-	675	259	602	3 063	20	21

Биеэ үнэлэгчдийн 97.9 хувь нь бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэдэг ба тэдгээрийн 62.3 хувь нь байнга, 23.0 хувь нь ихэнх тохиолдолд, 14.7 хувь нь заримдаа хамгаалах хэрэгсэл хэрэглэдэг байна.


Бэлгийн замаар дамжих халдварт өвчин ямар замаар халдварладаг талаар биеэ үнэлэгчдээс тодруулахад 92.2 хувь нь бэлгийн замаар, 2.8 хувь нь зүү тариур, эмнэлгийн хэрэгслээр, 2.2 хувь нь мэдэхгүй, 2.1 хувь нь ахуйн замаар, 0.6 хувь нь үнсэлцэх үед, 0.1 хувь нь бусад буюу цусаар дамждаг гэсэн ойлголттой байна.

Бэлгийн замын халдварт өвчин туссан үед илрэх шинж тэмдгийн талаар 48.8 хувь нь сайн мэддэг, 41.6 хувь нь бага зэрэг мэддэг, 9.6 хувь нь ямар шинж тэмдэг илэрдгийн мэддэггүй байна.

Биеэ үнэлэгчдийн 51.3 хувь нь хааяа нэг бэлгийн замаар халдварлах өвчний шинжилгээнд хамрагддаг байхад, 35.7 хувь нь байнга, 13.0 хувь нь огт хамрагдаж байгаагүй байна.


Зураг 3.34.

БЗДХ-ын шинжилгээнд сүүлд хамрагдаж байсан хугацаа, хувиар



Зураг 3.35.

БЗДХ тусч байсан биеэ үнэлэгч, эмчлүүлж байсан, эсэхээр, хувиар



Биеэ үнэлэгчдийн 35.8 хувь нь бэлгийн замаар дамжих халдварт өвчин тусч байсан ба тэдний 96.2 хувь нь уг өвчнөө эмчлүүлж байжээ. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин туссан үедээ эмчилгээ хийлгээгүй болон тогтмол шинжилгээнд хамрагддаггүй биеэ үнэлэгчдийн хувьд ДОХ/ХДХВ-ийн халдвар авах болон эрүүл мэндийн хувьд ямарваа нэг өвчин авах нөхцлийг бүрдүүлж байж болох хэрэг юм.

3.5 Согтууруулах ундаа ба мансууруулах бодисын хэрэглээ

Биеэ үнэлэгчдийн дунд хааяа архи хэрэглэдэг хүн 76.6 хувьтай байгаа бол хэрэглэдэггүй 15.0 хувь, байнга 7.3 хувь, хэтрүүлж хэрэглэдэг хүн 1.1 хувьтай байна.

Хүснэгт 3.13.

**Биеэ үнэлэгчдийн архины хэрэглээ,
насны бүлэг, хувиар**

Насны бүлгээр	Бүгд	Хааяа нэг	Байнга	Хэтрүүлж хэрэглэдэг	Хэрэглэдэггүй
18-20	586	13.1	13.9	0.0	10.6
21-24	1 452	33.8	24.2	3.9	24.1
25-29	1 017	23.8	15.3	32.7	15.1
30-34	750	14.4	27.7	26.9	18.6
35-39	572	10.0	10.0	9.6	25.4
40-44	189	3.5	6.8	23.1	4.2
45-49	55	0.9	2.1	3.8	2.0
50 ба түүнээс дээш	19	0.5	0.0	0.0	0.0
Хувь	-	100.0	100.0	100.0	100.0
Тоо	4 640	3 554	337	51	698

Судалгаагаар биеэ үнэлэгчдийн 2.5 хувь нь ямар нэгэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис хэрэглэдэг ба тэдний хоёр хүн тутмын нэг нь 25-29 насныхан, таван хүн тутмын нэг нь 18-24 насныхан, арван хүн тутмын нэг нь 30-44 насныхан байлаа. Эдгээр мансууруулах бодис хэрэглэдэг биеэ үнэлэгчдийн 20.9 хувь нь каннабис гэдэг бодисыг тарьж болон үнэрлэж хэрэглэдэг бол, 20.0 хувь нь никотин татаж, 6.1 хувь нь цавуу үнэрлэж, 5.2 хувь нь олсны ургамал үнэрлэж болон татаж, 2.6 хувь нь кокаин тарьж хэрэглэдэг байхад биеэ үнэлэгчдийн 45.2 хувь нь хэрэглэж буй бодисынхоо нэрийг мэддэггүй, нэр үл мэдэх өвс үнэрлэж болон татаж хэрэглэдэг байна. Харин нийт биеэ үнэлэгчдийн 16.6 хувь нь тайвшруулах эм хэрэглэдэг ба тэдний арван хүн тутмын нэг нь хааяа хэрэглэдэг байна.

3.6 Хүн худалдаалах гэмт хэргийн тухай мэдлэг, хандлага

Судалгаагаар биеэ үнэлэгчдээс хүн худалдаалах гэмт хэргийн талаар сонсож байсан эсэхийг асуухад 93.6 хувь энэ талаар сонсож байсан гэж хариулжээ. Мөн биеэ үнэлэгчдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэл хэр байдгийг тэднээс тодруулахад 90.8 хувь нь эрсдэлтэй гэж хариулжээ.

3.7 Ирээдүйн зорилго


Судалгааны нэг гол зорилго бол биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн талаарх мэдээлэл гаргахаас гадна мөн тэдний ирээдүйн зорилго, хүсэл эрмэлзлэлийг тэдэнтэй ярилцан, хууль эрх зүйн хамгаалалтыг сайжруулах, нийгэмшүүлэх эерэг тал руу чиглүүлэх явдал юм.

Биеэ үнэлэгчдийн 77.1 хувь нь гадаадад сурч, ажиллахыг хүсдэг ба хэрэв хэн нэгнээс гадаадад сурч, ажиллах санал хүлээн авбал 47.8 хувь нь хэн санал тавьснаас шалтгаална, 23.3 хувь нь хүлээн авна гэсэн бол 19.3 хувь нь хүлээн авахгүй, 9.6 хувь нь сайн мэдэхгүй, байдлаасаа болно гэж хариулсан байна.

Биеэ үнэлэгчдийн цаашдын зорилгын талаар ярилцахад таван хүн тутмын нэг нь тогтмол цалин хөлстэй ажилтай болох, хувийн бизнес эрхлэх, арван хүний нэг нь өөрийн гэсэн амьдрах орон байртай болох, сайхан амьдрах, сурч боловсрох, мэргэжилтэй болох зорилго, эрмэлзэлтэй байна.


Зураг 3.36.

Биеэ үнэлэгчдийн цаашдын зорилго, хувиар



Зураг 3.37.

Биеэ үнэлэгчдийн цаашид биеэ үнэлье гэж бодож буй хугацаа, хувиар



Судалгаагаар биеэ үнэлэгчдийн 71.8 хувь нь биеэ үнэлэхээ больж чадна гэж боддог бол 14.2 хувь нь тухайн үеийн байдлаасаа болно, 9.9 хувь нь мэдэхгүй, 4.1 хувь нь чадахгүй гэж боддог байна. Чадахгүй гэсэн хүний шалтгааныг тодруулахад 60.5 хувь мөнгө хэрэгтэй, 20.0 хувь нь хэлж мэдэхгүй, 4.7 хувь нь орон гэргүй, 3.7 хувь нь ажилд орж чадахгүй, 3.2 хувь нь өөр хялбар мөнгө олох арга олдохгүй байна гэсэн бол 7.9 хувь нь бусад шалтгаануудыг дурьджээ.

Бүлэг 4

БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ХҮҮХЭД


БҮЛЭГ 4. БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ХҮҮХЭД

Энэ бүлгээр биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн дунд явуулсан судалгааны дүнг үндэслэн бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн нас, ерөнхий шинж байдал, эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ХДХВ өвчний талаарх мэдлэг, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ, хүн худалдаалах гэмт хэргийн тухай тэдний үзэл бодол зэргийг харуулахыг зорьсон.


4.1 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тоо, насны бүлэг, дүүргээр, байршлаар

Судалгаанд нийт 4683 биеэ үнэлэгч хамрагдсаны 43 буюу 0.9 хувь нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд байна. Бэлгийн мөлжлөгт өртсөн таван хүүхдийн дөрөв нь 30 ба түүнээс дээш суудалтай, караоке, баар, цэнгээний газраас үйлчлүүлэгчдээ олж авдаг байна. Судалгаанд хамрагдсан бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн 95.3 хувь нь 17 настай, 4.7 хувь нь 15 настай охидууд байсан.

Зураг 4.1
Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд,
дүүргээр, хувиар



Зураг 4.2
Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд,
байршлаар, хувиар



Судалгаанд хамрагдсан бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 4.7 хувь нь 14 настайдаа, 95.3 хувь нь 16 настайдаа анх бэлгийн мөлжлөгийн хохирогч болж эхэлсэн байна.

4.2 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн ерөнхий шинж байдал

Судалгаанд хамрагдсан бэлгийн мөлжлөгт өртсөн охидын боловсролын түвшинг авч үзэхэд 14.0 хувь нь одоогоор коллежид суралцагчид, 46.5 хувь нь бага боловсролтой, 39.5 хувь нь боловсролгүй хүүхдүүд байна. Бараг арван хүүхдийн ес нь санхүүгийн бэрхшээлээс болж ерөнхий боловсролын сургуулиас завсардсан байна (Хүснэгт 4.1). Сургууль завсардсан охидууд ямар нэгэн албан бус сургалтанд хамрагдаж байгаагүй байна.

Хүснэгт 4.1

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн сургуулиас завсардсан шалтгаан, завсардсан ангиар


Анги	Санхүүгийн бэрхшээл	Ажил хийх гээд	Бичиг баримтгүй/бүртгэл байхгүй	Нийт
5	88.2	11.8	-	100.0
8	-	-	100.0	100.0
9	88.2	11.8	-	100.0
Бүгд	81.1	10.8	8.1	100.0

Одоогоор коллежид суралцаж байгаа гэсэн охидууд үйлчилгээний газраас үйлчлүүлэгчээ олж авдаг байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 34.9 хувь нь одоогийн оршин сууж буй газартаа 1 хүртэлх жил, 51.2 хувь нь 1-4 жил, 14.0 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатайгаар амьдарч байна. Шилжин ирсэн охидын 40 гаруй хувь нь одоогийн оршин сууж буй газартаа бүртгэл хийлгээгүй гэсэн байна. Бүртгэл хийлгээгүй гол шалтгааныг тодруулахад 88.2 хувь нь бичиг баримтгүй, 11.8 хувь нь шилжүүлэггүй хэмээн тайлбарлаж байв. Охидын 81.1 хувь нь ганцаараа, 18.9 хувь нь гэр бүлийнхэнтэйгээ шилжин ирсэн байна. Харин шилжин ирэх болсон шалтгааныг тодруулахад 40.5 хувь нь найз нөхөд/ хамаатан саднаа дагаад, 37.8 хувь нь суралцахаар, 16.2 хувь нь эцэг, эх, гэр бүлээ дагаад, 5.4 хувь нь ажил олж хийхээр ирсэн гэж хариулж байсан. Аливаа хүн бие хүн болж өсөж, хүмүүжихэд хүүхэд насаа өнгөрөөсөн үе, гэр бүлийн орчин юунаас ч илүү чухал байдаг билээ. Харин бэлгийн мөлжлөгт өртсөн дөрвөн охидын гурав нь гэр бүлийнхэнтэйгээ ойлголцож чаддаггүй гэж хариулж байв (Зураг 4.3).


Зураг 4.3

Бэлгийн мөлжлөгт өртсөн охид, гэр бүлийнхэнтэйгээ хэр ойлголцдог талаар, хувиар



Зураг 4.4

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн амьдардаг газар, хувиар



Гэр бүлийнхэнтэйгээ байхад ямар нэгэн дарамт, шахалт тулгарч байсан эсэхийг тодруулахад: охидын гуравны нэг нь сэтгэл зүйн дарамт/заналхийлэлд өртдөг, зоддог, сургуульд суралцуулдаггүй, гэрээсээ хөөдөг гэсэн хариултуудыг өгч байсан. Бэлгийн мөлжлөгт өртсөн таван охидын нэг нь буюу 23.3 хувь нь одоогоор гэр бүлийнхэнтэйгээ цуг амьдардаг гэсэн бол 34.9 хувь нь ганцаараа, 34.9 хувь нь найзуудтайгаа, 6.9 хувь нь найз залуутайгаа хамт амьдардаг гэжээ. Долоон охидын нэг нь өөрийн гэсэн амьдрах сууцтай гэсэн бол үлдсэн нь хамаатан садан, халамжийн төв, буудал, түрээсийн байранд амьдардаг гэж хариулж байв (Зураг 4,4). Бэлгийн мөлжлөгт өртсөн хоёр хүүхдийн нэг нь урьд нь ямар нэгэн ажил эрхэлж байсан байна (Хүснэгт 4.2). Охидын ажил хийх болсон шалтгаан нь сургууль завсардалтанд нь нөлөөлсөн ч байх талтай.

Хүснэгт 4.2

Бэлгийн мөлжлөгт өртөхөөс өмнө нь ямар нэгэн ажил эрхэлж байсан эсэх, дүүргээр

Дүүрэг	Урьд нь ажил эрхэлж байсан эсэх		Нийт	Ажил эрхэлж эхэлсэн нас	
	Үгүй	Тийм		14 нас	15 нас
Хан-уул	25.0	75.0	100.0	-	100.0
Баянзүрх	100.0	-	100.0	-	-
Сүхбаатар	54.5	45.5	100.0	100.0	-
Бүгд	48.8	51.2	100.0	100.0	100.0

байна. Эндээс харахад бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд биеэ үнэлэх замд татагдан орох магадлал нь өндөр юм байна гэж дүгнэж болохоор байна.


Зураг 4.6-аас харахад гэр бүлийн хүнд хэцүү амьдрал, гэр бүлийн хүрээн дэхь хүчингийн гэмт хэрэг, санхүүгийн бэрхшээл, гэнэн томоогүй шохоорхол, бусдад уруу татагдах байдлаас болж охидууд маань бэлгийн мөлжлөгт өртсөөр байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн арван охины нэг нь зуучлагчтай, зуучлагчаараа дамжуулж хөлсөө авдаг байхад, харин үлдсэн хувь нь шууд хөлсөө авдаг байна. Зуучлагчтай охидууд бүгд зуучлагчдаа өр, зээлтэй байна. Охидыг зуучлагчид нь 21-30 насны эмэгтэй хүмүүс байдаг байна. Эдгээр зуучлагчдыг өмнө нь таньдаг байсан, хуурай эгч, дүүс байцгаасан болон найзаараа дамжуулж танилцсан байжээ.

Охидод зуучлагчийн зүгээс хааяа зодох, айлган сүрдүүлэх, өр, зээлээ төлөхийг шаардах, биеэ үнэлдэг гэж бусдад хэлнэ гэж сүрдүүлэх, олны өмнө гутаан доромжлох зэрэг дарамт, шахалтыг үзүүлдэг байна. Үүний зэрэгцээ зуучлагч охидод шөнийн цагаар үнэгүй унаагаар үйлчлэх, гэртээ үнэгүй хонуулах, баар цэнгээний газарт оруулах зэрэг үйлчилгээ үзүүлдэг байна.

Зураг 4.7

Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын сарын дундаж орлого, хувиар



Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын дийлэнх нь (давхардсан хариултаар) олсон орлогоо өөрт хэрэгтэй эд зүйлс (76.7 хувь) болон хоол хүнс (51.2 хувь) худалдан авахад

хэрэглэдэг байна. Мөн тодорхой хэсгийг боловсролд (48.8 хувь), гэр бүлийнхэндээ (46.5 хувь), өр, зээл төлөхөд (46.5 хувь), гоо сайхандаа (14.0 хувь), байрны түрээс төлөхөд (4.7 хувь), эрүүл мэнддээ (4.7 хувь) зарцуулдаг байна.

Охидуудын одоогийн биеэ үнэлж байгаа шалтгааныг авч үзвэл: (давхардсан хариултаар) 14.0 хувь нь сонирхоод, 41.9 хувь нь найз нөхдөө дагаад, 9.3 хувь нь гэр бүлээ тэжээхээр, 14.0 хувь нь сургалтын төлбөрөө олохоор, 9.3 хувь нь зуучлагчид тавьсан өрөө төлөхөөр гэж хариулж байв.

Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 7.0 хувь нь биеэ үнэлж байхдаа үйлчлүүлэгчдээс болж гэмтэл, бэртэл авч байсан байна.

Охидод үйлчлүүлэгчийн зүгээс хааяа хэл амаар доромжлох, дээрэмдэх, бага мөнгө төлөх асуудал гардаг бөгөөд ёс бус зүйл шаардах (39.5 хувь), зодох (4.7 хувь) зэрэг дарамт, шахалтыг үзүүлдэг байна.

Охидууд өдөрт 1-5 хүнд үйлчилдэг байна. Тэднээс үйлчлүүлэгчдийн насыг тодруулахад 18-50 орчим насны хүмүүс байдаг гэж хэлж байв. Бараг таван охидын нэг нь гадаад хүмүүст үйлчилдэг гэж байв. Тэднээс ямар улсын иргэд байсныг тодруулахад БНХАУ, Япон, БНСУ, Вьетнам, АНУ, ХБНГУ, ОХУ-ын хүмүүс байсан гэв. Охидын 88.4 хувь нь үйлчлүүлэгчээсээ бэлгийн харьцаанд орохоос өөр ямар нэгэн санал хүлээн авч байгаагүй гэсэн бол 4.6 хувь нь монголд өөр ажил эрхлэх санал, 7.0 хувь нь гэрлэх санал хүлээн авч байсан байна. Охидын 7.0 хувь нь үйлчлүүлэгчид нь тэднээс охид, эмэгтэйчүүдийг олж өгөөч гэсэн санал тавьж байсан гэж хэлж байв. Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 80 гаруй хувь нь ямар нэгэн аюул учирсан тохиолдолд хамгийн түрүүнд цагдаад хандаж байжээ. Харин 7.0 хувь нь хамтран ажиллагчиддаа хандсан бол 4.7 хувь нь зуучлагчиддаа, 4.7 хувь нь хэнд ч хандаагүй байна. Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 41.9 хувь нь биеэ үнэлсэний улмаас баривчлагдаж, торгуулах хуулийн арга хэмжээ авахуулж байсан байна. Охидын 51.2 хувь нь хэр удаан биеэ үнэлэхээ мэдэхгүй байгаа бол 14.0 хувь нь нэг сар үнэлнэ гэсэн ба 34.9 хувь нь 6 сар үнэлнэ гэсэн хариултыг өгч байсан. Харин охидоос дуртай үедээ биеэ үнэлэхээ больж чадах эсэхийг асуухад 4,7 хувь нь тухайн үеийн байдлаасаа болно гэсэн бол үлдсэн хувь нь больж чадна гэж хариулж байв.

4.4 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн талаарх нэмэлт мэдээлэл


Бид “Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа”-нд хамрагдсан гудамж, талбайд зогсож буй нийт 600 гаруй биеэ үнэлэгчдээр дамжуулан бэлгийн мөлжлөгт өртөж буй хүүхдийн талаарх нэмэлт мэдээллийг цуглуулсан болно. Нэмэлт мэдээлэл цуглуулахад хариулагчид өөрсдөд нь дараа нь ямар нэгэн эрсдэлтэй зүйл болж болох талаас нь эмээж судалгаанд хариулахаас татгалзаж байсныг энд дурдах нь зүйтэй байх.

Нэмэлт мэдээллийн үндсэн дээр бид бэлгийн мөлжлөгт өртсөн дунджаар 140 гаруй хүүхэд байна гэсэн тоог тооцож гаргаж ирсэн болно. Эндээс үзэхэд бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн дийлэнх нь зуучлагчдын эрхшээл дор, нуугдмал байдалд биеэ үнэлж байна. Зуучлагчид хүүхдийг зочид буудал, түрээсийн сууц, өөрсдийнхөө гэрт (Салхит, Ханын материал, Дарь эх, Таван шар, Алтан-Өлгий, Хайлааст, 7 буудал гэх мэт гэр хороололд) байлгадаг байна. Бид мэдээлэл өгөгчдөөс охидыг байрлуулдаг газраа байнга сольдог эсэх талаар асуухад зочид буудалд байрлуулдаг гэж хариулсан хүмүүсийн 22.2 хувь нь зочид буудлаа ойр ойрхон сольдог гэсэн. Харин түрээсийн сууцанд байрлуулдаг гэсэн хүмүүсийн 12.7 хувь нь зуучлагчид түрээсийн байраа ойр ойрхон сольдог гэж хариулсан байна. Эндээс үзвэл зуучлагчид охидыг байрлуулдаг газраа байнга, ойр ойрхон сольдоггүй юм байна.

Зураг 4.8


Зураг 4.9

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг байрлуулдаг газар, хувиар*



Эх үүсвэр: *-Нэмэлт мэдээлэл

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн насны бүтэц, хувиар*



Үгэллэл: *-Í үй үөдöй үйүүүө



Бид бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг байрлуулдаг байрны нөхцөл нь ямар байдгийг тодруулж асуухад 50 гаруй хувь нь очиж үзээгүй болохоор сайн мэдэхгүй гэсэн бол 25.5 хувь нь тааруухан, 10.2 хувь нь боломжийн, 8.2 хувь нь дунд зэрэг байдаг гэж хариулав. Нэмэлт мэдээллээс харахад бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн хамгийн бага нь 13 настай хүүхдүүд байдаг байна (Зураг4.9).

Зураг 4.10

Зураг 4.11

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг зуучилдаг хүмүүс, хувиар

Бэлгийн мөлжлөгт өртөж буй байдал, хувиар



Бэлгийн мөлжлөгт өртөж буй хүүхдүүдийг хэн зуучилж, мөлжиж буй талаар тодруулахад урьд нь биеэ үнэлэгч байсан нэр бүхий эмэгтэйчүүд (Бүргэд, Сорвит, Онон, Мийгаа, Цоомоо, Хар туяа, Равдангийн Оюунаа, Болдмаа, Барзаак Туяа, бүдүүн Тамираа, шулга Сараа, Бялзуухай, Нандиа гэх мэт), мөн гэр бүлийнхэнтэйгээ хамтран (Оюунаа-Манлай, Жижгээ-Ганаа, 49 гэх мэт) үйлддэг гэжээ. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг зуучилдаг хүмүүсийн талаар ярилцахад хариулагчдын 16.8 хувь нь гэр бүлээрээ (эхнэр, нөхөр, дүүтэйгээ) хамтран, 10.9 хувь нь найз нөхөдтэйгээ хамтран хүүхдүүдийн биеийг үнэлүүлдэг гэж хариулж байв. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн биеийг үнэлүүлдэг хүмүүсийн 40 орчим хувь нь охидыг дарамталдаг, 18.4 хувь нь охидыг зоддог, мөн зарим нь өөрсдийн гэсэн бүлэглэлтэй бөгөөд зугтсан, эсэргүүцсэн охидыг тэднээр зодуулах эсвэл гэмт хэргийн хүрээнийхэнд өгч явуулан зодуулж, дарамтлуулдаг гэсэн бол 5 орчим хувь нь мөрдөн мөшгидөг, гэрээс нь очоод

Хүснэгт 4.3

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн анх бэлгийн харьцаанд орсон нөхцөл, хувиар

Үзүүлэлт	Найз залуу	Таньдаг хүн	Таньдаггүй хүн	Нийт
Өөрийн хүслээр	-	4.7	-	100.0
Харилцан тохиролцож	-	34.9	-	100.0
Санамсаргүй тохиолдлоор	7.0	-	4.7	100.0
Хүчиндүүлж	-	34.9	-	100.0
Хууран мэхлэгдэж	-	14.0	-	100.0
Бүгд	7.0	88.4	4.7	100.0

Охидын 81.4 хувь нь үйлчлүүлэгчтэй голдуу бэлгийн харьцаанд ордог гэсэн бол тэдний 34.9 хувь нь бэлгэвч огт хэрэглэдэггүй бол 7.0 хувь нь байнга, 34.9 хувь нь заримдаа, 4.7 хувь нь ихэнх тохиолдолд бэлгэвч хэрэглэдэг байна. Тэдний 55.8 хувь нь бэлгийн замаар дамжих халдварт өвчин бэлгийн хавьталд орох үед халдварладаг гэсэн бол 44.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 34.9 хувь нь бэлгийн замаар дамжих халдварт өвчин туссан үед илрэх шинж тэмдгүүдийг мэднэ, 4.7 хувь нь бага зэрэг мэднэ, 60.5 хувь нь мэдэхгүй гэсэн нь энэ талаарх мэдлэг, ойлголт дутмаг байгааг харуулж байна.

Охидын талаас илүү хувь нь БЗДХ/ДОХ/ХДХВ-ын шинжилгээ огт өгч байгаагүй бол 34.9 хувь нь 1-3 сарын өмнө, бусад нь 1 жил ба түүнээс дээш хугацаанд шинжилгээнд хамрагдаагүй гэсэн байна. Харин 60 гаруй хувь нь БЗДХ тусч байгаагүй бол 34.9 хувь нь тусч, эмчилгээ хийлгэж байсан байна.

4.6 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ

Судалгаанд хамрагдсан бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 50 гаруй хувь нь согтууруулах ундаа хааяа хэрэглэдэг бол 4.7 хувь нь байнга хэрэглэдэг, 39.5 хувь нь огт хэрэглэдэггүй байна. Охидын 95.3 хувь нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис хэрэглэдэггүй ба 4.7 хувь нь эфирын гэгддэг мансууруулах бодисыг ууж хэрэглэдэг байна. Охидын 90 гаруй хувь нь тайвшруулах эм огт хэрэглэдэггүй бол үлдсэн хувь нь байнга хэрэглэдэг байна.

4.7 Хүн худалдаалах гэмт хэргийн тухай мэдлэг, хандлага

Судалгаанд хамрагдсан бэлгийн мөлжлөгт өртсөн охидоос хүн худалдаалах гэмт хэргийн талаар сонсож байсан эсэхийг асуухад 95.3 хувь нь сонсож байсан бол 4.7 хувь нь сонсож байгаагүй байна. Биеэ үнэлэгчдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй гэж боддог эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдсан охидууд бүгд эрсдэлтэй гэж хариулсан байна.

4.8 Ирээдүйн зорилго

Судалгаанд хамрагдсан бэлгийн мөлжлөгт өртсөн охидын ирээдүйн зорилго, ирээдүйгээ хэрхэн төсөөлж, юуг хүсч, мөрөөдөж байдаг талаар тэдэнтэй ярилцсан юм. Тэдний 34.9 хувь нь тогоочийн сургалтанд сууж, тогооч болох хүсэлтэй байгаа бол 16.3 хувь нь сургуульд сурах, 34.9 хувь нь мэргэжилтэй сайн хүн болж, гэрийнхэндээ туслах, 14.0 хувь нь сургуулиа төгсөж, ажил хийж сайхан амьдарна гэж хэлж байв.

Охидоос гадаадад сурч, ажиллах хүсэлтэй байгаа болон хэрэв гадаадад ажиллах санал ирвэл хүлээн авах эсэхийг тодруулахад хоёр охины нэг нь гадаадад сурч, ажиллах хүсэлтэй байгаа бөгөөд үлдсэн нь хүсэлгүй байна гэсэн бол ийм санал тавибал 80 орчим хувь нь дуртайяа хүлээн авах бол 16.3 хувь нь сайн мэдэхгүй, үлдсэн хувь нь хүлээн авахгүй гэжээ.

Бүлэг 5

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын 95.3 хувь нь 16 настайдаа анх бэлгийн мөлжлөгийн хохирогч болж эхэлсэн гэсэн үр дүн гарсан нь Монгол Улсын Эрүүгийн тухай хууль дахь 16-17 насны хүүхэдтэй насанд хүрсэн хүн хурьцал үйлдэж болохыг зөвшөөрсөн заалт амьдрал дээр ийм үр дагавар авчирч байгааг харуулж байна. Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд хүүхэд гэдгийг 18 насанд хүрээгүй хүнийг хамруулна гэж заасны дагуу Эрүүгийн хуулийн холбогдох заалтыг 18 насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хичирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс хамгаалахад чиглүүлэн өөрчлөх хэрэгтэй байна.
- Биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь өмнө нь хүчиндүүлж байсан гэжээ. Мөн бэлгийн мөлжлөгт өртөж буй 18 нас хүрээгүй хүүхдийн 44.2 хувь нь хүчиндүүлж байсан ба хүчиндүүлсэн арван охидын есыг нь хойд эцэг нь хүчиндсэн байна. Эндээс үзэхэд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн хооронд уялдаа байна гэж дүгнэж болохоор байна. Тиймээс хүүхдийн бэлгийн хүчирхийллийн хэргийг таслан зогсоох, шийтгэх, хохирогч хүүхдийг нэн даруй нөхөн сэргээхэд холбогдох эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүүхдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.
- Хүүхдийн биеийг үнэлүүлж буй зуучлагчид охидыг байрлуулдаг гэр, түрээсийн байраа ойр ойрхон сольдоггүй юм байна. Гэвч эдгээр хүмүүс хууль хяналтаас гадуур явсаар байгаа нь сонирхол татаж байна.

Насанд хүрээгүй охидыг зуучлан мөлжиж буй гэмт хэрэгтнүүдийн дийлэнхи нь хариуцлага хүлээхгүй байгаа ба зарим хэсэгт нь Эрүүгийн хэргийн 124-р зүйлд¹ заасны дагуу хариуцлага оногдуулж байгаа ч энэ нь хөнгөн төрлийн гэмт хэрэгт хамаарагдан өршөөлийн хуулиар ивээгдэж, ял завшиж дахин энэ гэмт хэргээ үргэлжлүүлэн үйлдсээр байна. Хуулийн байгууллагад шалгагдаад өршөөгдсөн хүмүүс улам илүүтэйгээр хохирогч болон тэдний гэр бүлийнхнийг айлган сүрдүүлж, заналхийлэн, далд аргад шилжиж буйд нэн даруй анхаарах шаардлагатай байна. Монгол Улс хэдийгээр НҮБ-ын Палермогийн Протоколд нэгдэн орсон хэдий ч хуулиа

¹ Биеэ үнэлэхийг зуучлах, зохион байгуулах, орон байраар хангах”

Протоколын заалтанд бүрэн нийцүүлээгүйн улмаас бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг өнөөг хүртэл хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэж үзэхгүй “насанд хүрээгүй биеэ үнэлэгч” хэмээн үзэж, гэмт хэрэгтнүүдэд хөнгөн ял оноож, хүүхдийн эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байна. Тиймээс насанд хүрээгүй хүүхдийн биеийг үнэлүүлж мөлжсөн хэргийг шийдвэрлэхдээ олон улсын гэрээ конвенцийн заалтыг дагаж мөрдөх, үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөн сайжруулах шаардлагатай байна. Хүүхдийн биеийг үнэлүүлсэн хэргийг хүн худалдаалсан гэмт хэрэг гэж үзэхийг Палермогийн Протоколд заасан байдгийг үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо анхааралдаа авах нь зүйтэй.

- Зуучлагчдын эрхшээл дор бэлгийн мөлжлөгт өртсөн охидыг чөлөөлөхөд холбогдох хуулийн байгууллага нэн даруй үр дүнтэй арга хэмжээ авах хэрэгтэй байна. Судалгааны явцад биеэ үнэлэгчид охидын биеийг үнэлүүлдэг болох Жижгээ, 49, Бүргэд, Сорвит, Онон, Мийгаа Болдмаа, Цоомоо, Барзаак Туяа, Хар Туяа, Равдангийн Оюунаа..... гэсэн нэрс хэлж байсан бөгөөд зарим эмэгтэйчүүдийг нөхөртэйгээ хамт 14-18 насны охидыг зуучилдаг гэж хэлж байлаа. Зуучлагчид Эрүүгийн хуулийн 124-р зүйлээр (Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах) хэрэг үүсгүүлэн шалгагддаг ч өршөөлийн хуульд хамрагдаж “Монголын төр, хууль, монголын цагдаа намайг яаж ч чадахгүй... “хэмээн өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгсөн охидыг улам ихээр дарамталдаг болсон тухай олон эмэгтэйчүүд хэлсэн. Тиймээс хуулийн заалтуудыг өөрчилж, яаралтай оновчтой болгох, хөнгөн гэмт хэрэгт тооцохгүй байх талаар бодитой ажил хийх нь гэмт хэргийг таслан зогсооход чухал үр дүн болно гэж үзэж байна.
- Дотоодод үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэргэжлийн бүлгүүд, ялангуяа хууль хяналтын байгууллагын ажилтнууд нэгдсэн ойлголттой болох хэрэгцээ тулгарч байгаа нь энэ судалгаагаар харагдлаа.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд өөрсдийгөө хүн худалдаалах гэмт хэргийн (ХХГХ) хохирогч болж байгаагаа мэдэхгүй байгаагаас гадна тэдний 80 орчим хувь нь гадаадад гарах саналыг дуртайяа хүлээн авна гэсэн хариултаас харахад хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болох магадлал өндөр байгаа нь илэрхий байна.

- Төрөөс хохирогчдод зориулсан нийгмийн ажлын цогц үйлчилгээг сайжруулах, энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагуудад санхүүжилт төсвөөс хуваарилан олгох, хохирогч, гэрч хамгааллын тогтолцоог яаралтай бий болгох шаардлагатай байна.
- Үйлчилгээний газарт олон газраас хяналт хийж байгаа нь сайшаалтай боловч нөгөө талаар нэг дор төвлөрч чадахгүй байгаа байдал харагдаж байна. Үйлчилгээний байгууллагуудын бүртгэл, хаягжилт, үйл ажиллагаа явуулж байгаа талаарх мэдээллийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Учир нь зөвшөөрөл өгдөг, хяналт тавьдаг байгууллагуудын тоо мэдээ, нэрс нь хоорондоо зөрүүтэй байгаагаас зөвшөөрлөө хүлээж байгаа, сунгуулах гэж байгаа, дүүргийн шалгалтын хүмүүс аваад явсан, нийслэлийн шалгалтын хариуг хүлээж байна г.м тайлбараар зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгааг таслан зогсоох шаардлагатай.
- Биеэ үнэлэгч эмэгтэйчүүдээр дамжуулан бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн талаарх мэдээллийг олж авах судалгааны аргаас гадна бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн талаарх мэдээллийг олж илрүүлэх өөр бусад илүү үр дүнтэй арга, хувилбарыг судлан үзэх хэрэгтэй байна.
- Бэлгийн мөлжлөгт охидыг илтээр өртүүлдэг үйлчилгээний газруудын нэр, хаяг их солигдон өөрчлөгдөх боловч, үйлчилгээ хүргэдэг, зуучилдаг ажилчид нь огт өөрчлөгддөггүй нь анхаарал татаж байлаа. Тиймээс тухайн газрын үйл ажиллагааг нь зогсоохдоо дахин энэ чиглэлийн үйлчилгээг тухайн объектод хийж болохгүйгээр зохицуулах хэрэгтэй гэж үзлээ.
- Судалгааны асуулганд хариулсан байдлаас үзэхэд биеэ үнэлж байгаа 30 хүртэлх насны эмэгтэйчүүд хөдөө орон нутгаас ирсэн гэх бөгөөд анх биеэ үнэлсэн газар нь тухайн орон нутаг гэж хариулснаас харахад биеэ үнэлэлт нь нийслэлээс гадна хөдөө орон нутагт байгаа тул цаашдаа судалгааны зорилтот бүлгийг улсын хэмжээнд хүн ам ихтэй төв суурин газруудаас авах нь зүйтэй гэж үзэж байна.
- Зарим биеэ үнэлэгчид өглөө, өдрийн цагаар дуудлагаар, интернэтээр тохиролцон биеэ үнэлж орой, үдшийг гэртээ өнгөрөөдөг, энэ нь эцэг, эх, гэр бүлийнхэндээ хар авахуулахгүй байж чаддаг гэсэн байсан. Тэдний

үйлчлүүлэгчид нь ихэнхдээ албан ажилтай хүмүүс байдаг гэдэгт онцгойлон анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байна.

- Налайх дүүргийн биеэ үнэлэгчдийн талаарх судалгааны үр дүнгээс харахад тэд хот руу явах, уурхайн ам явж биеэ үнэлэх эсвэл дулааны улиралд тоосгоны үйлдвэр, хятад ажилчид ажиллаж буй барилгын талбай дээр очиж биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүд нэлээд байна. Ийнхүү дулааны улиралд биеэ үнэлэгчдийн байршил нэлээд өөрчлөгдөх хандлага ажиглагдсан тул биеэ үнэлэгчдэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг энэ нөхцөл байдлыг харгалзан явуулах нь зүйтэй.
- Насанд хүрээгүй биеэ үнэлсэн охид цагдаагаар хамгаалуулах биш аль болох зугтдаг нь Садар самуун явдалтай тэмцэх хуультай холбоотой гэж үзэж байна. Тэднийг баривчилж, торгож байгаа боловч тэднийг худалдан авагч нарт болон зуучлагч нарт зохистойгоор хариуцлага тооцож чадахгүй байгаа нь насанд хүрээгүй хүүхдийн эсрэг ноцтой гэмт хэргийг таслан зогсооход сөргөөр нөлөөлж байна үзэж байна. Тиймээс нэн даруй энэ хуулийг өөрчлөх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ 1

СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ДИЗАЙН

Биеэ үнэлэгчид болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгааны түүврийн дизайн

1. Судалгааны зорилго:

- Улаанбаатар хотод бэлгийн мөлжлөгт өртөж байгаа хүүхэд болон биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн тоог гаргах;
- Охид, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөгт өртсөн болон биеэ үнэлж байгаа шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох;
- Хүүхэд болон насанд хүрэгчид биеэ үнэлж байгаа үндсэн шалтгаан, үр дагаварт үнэлгээ өгөх;
- Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийн нийгэм-эдийн засгийн байдлыг тодорхойлох;
- Биеэ үнэлэх явдлаа зогсоохыг хүсэвч чадахгүй байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийн тоог гаргах;
- Хүүхдийн бэлгийн мөлжлөгийг таслан зогсооход чиглэсэн зөвлөмж боловсруулах

2. Судалгааны ач холбогдол:

Судалгааны хүлээгдэж байгаа үр дүн нь иргэд, төр засаг, ТББ-ууд, бусад оролоцогчдын хүүхэд, насанд хүрэгчдийн биеэ үнэлж байгаа байдлын талаарх мэдээллийг нэмэгдүүлэх, биеэ үнэлэлт, хүүхдийн бэлгийн мөлжлөгийг зогсоох хөтөлбөр боловсруулах, хөрөнгө санхүүжилт хуваарилах, хүүхдийн үндсэн эрхийг хамгаалах, тэднийг биеэ үнэлэх явдлаас гаргаж, ердийн амьдралд оруулж нийгэмшүүлэх эрх зүйн үйл ажиллагааг явуулах суурь мэдээлэл болно.

3. Судалгааны арга зүй:

3.1 Зорилтот эх олонлог

Улаанбаатар хотод хийх энэхүү судалгааны зорилтот хүн ам нь 18-аас доош насны бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд болон насанд хүрсэн биеэ үнэлэгчдийн тооноос

бүрдэнэ. Эдгээр хүмүүс байж болох эрсдэлтэй газрууд гэдэгт: (1) гудамж, талбай, (2) караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб, (3) массаж, сауны газруудыг хамруулсан. Караоке/баар/цэнгээний газар/шөнийн клубуудыг суудлын тоо буюу багтаамжаас нь хамааруулан 30 ба түүнээс бага суудалтай “Жижиг”, 30- аас дээш суудалтай “Том” гэж 2 хуваасан болно.

Түүврийн хүрээг дараах байршлын ангиллаар 6 бүлэг үүсгэн бүрдүүлсэн. Үүнд:

- 1) Гудамжны биеэ үнэлэгчид;
- 2) Албан ёсны бүртгэлтэй “ЖИЖИГ” буюу 30 хүртэл суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;
- 3) Албан ёсны бүртгэлтэй “ТОМ” буюу 30 ба түүнээс дээш суудалтай караоке/баар/цэнгээний газар/шөнийн клуб;
